



## ХБНГУ-ын Сорт хамгаалах тухай хууль



Герман-Монголын хамтын ажиллагааны  
“Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл

Улаанбаатар хот  
2018 он



# Сорт хамгаалах тухай хууль (Сорт хамгааллын эрхийн тухай хууль)

Батлагдсан огноо: 1985 оны 12-р сарын 11

Бүрэн эхээр:

"1997 оны 12 дугаар сарын 19-нд хэвлэгдсэн Сорт хамгаалах тухай хуульд (BGBl.<sup>1</sup> х. 3164) сүүлд 2017 оны 4 дүгээр сарын 13-ны хуулийн 6-р зүйлийн 37-р заалтаар (BGBl. I х. 872 нэмэлт өөрчлөлт оруулсан"

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Сортын хамгаалал (Сорт хамгааллын эрх) , тавигдах шаардлага

#### 1-р зүйл. Сортын хамгаалалд тавигдах шаардлага

(1) Ургамлын сортын (сортын)

1. ялгагдах байдал,
2. гомоген байдал,
3. тогтвортой байдал,
4. шинэлэг байдалболон
5. бүртгэж болохуйц оноосон нэрийг хамгаалалтад хамруулна.

(2) Европын Хамтын Нийгэмлэгийн хамгаалалтад багтсан сортод энэ хуулиар зохицуулагдах хамгаалалт олгогдохгүй.

#### 2-р зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1. "төрөл зүйл" гэж ургамлын зүйл, зүйлийн бүлэг, дэд зүйлийг;
- 1а. "сорт" гэж эргээд бүтэн ургамал бий болгох чадвартай, ангилал зүйн хамгийн доод төвшний тодорхой нэг таксонд хамаарах, ургамлын буюу ургамлын эд эрхтний бүрдэлийг; уг бүрдэл нь сорт хамгаалалд хамруулах шаардлагад нийцэх эсэхээс хамааралгүйгээр,
  - а) Тодорхой нэг генотипийн эсхүл тодорхой генотипийн бүрдлийн үүсгэх шинж тэмдгүүдийн илрэлээр тодорхойлогдохуйц,
  - б) эдгээр шинж тэмдгүүдийн ядаж аль нэгийнх нь илрэлээр бусад ургамлын буюу ургамлын эд эрхтний бүрдлээс ялгагдахуйц ба
  - с) өөрчлөгдөхгүйгээр үржих чадварынхаа хувьд бүрдэл гэж тооцогдохуйц байна.
2. "үржүүлгийн материал" гэж ургамал үйлдвэрлэх буюу бусад зориулалтаар газар тариаланд ашиглагдахаар зориулагдсан ургамал, ургамлын үр, бусад эд эрхтнийг;
3. "ашиглалт" гэж борлуулахаар санал болгох, нөөцлөн хадгалах, арилжааны зориулалтаар үзүүлдэнд ашиглах, ямар нэг зорилгоор бусдад дамжуулах үйл явцыг;
4. "мэдүүлэг гаргасан огноо" гэж сорт хамгаалуулах мэдүүлэг Холбооны Сортын албанд бүртгэгдсэн өдрийг;
5. "гэрээт улс" гэж Европын Эдийн Засгийн Бүсийн тухай гэрээний нэг тал болох улсыг;
6. "холбооны гишүүн" гэж Ургамлын Шинэ сортыг Хамгаалах Олон Улсын Холбооны гишүүн улсыг буюу улс хоорондын байгууллагыг.

<sup>1</sup>Холбооны (Бүгд Найрамдах Герман) Улсын Төрийн мэдээлэл.

### 3-р зүйл. Ялгагдах байдал

(1) Мэдүүлэг гаргасан огноог хүртэл танигдсан сортуудаас ядаж нэг гол шинж тэмдгийн илрэлээр ялгагдаж байвал уг сортыг ялгагдахуйц гэж үзнэ. Холбооны Сортын албанаас хүсэлтийн дагуу ургамлын төрөл зүйл тус бүрт сортын ялгагдах байдлыг илэрхийлэх гол шинж тэмдэгүүдийн талаар мэдээлэл өгнө; уг шинж тэмдэгүүд нь тодорхойлогдохуйц ба бичиглэгдэхүйц байна.

(2) Дараахь нөхцлийг хангасан сортыг танигдсан сорт гэж үзнэ. Үүнд:

1. сортын аль нэг албан жагсаалтад бүртгэгдсэн байх, эсхүл
2. сортын аль нэг албан жагсаалтад бүртгүүлэхээр хүсэлт гаргасан бөгөөд уг хүсэлт нь зөвшөөрөгдсөн байх, эсхүл
3. үржүүлгийн материал буюу ургац нь арилжааны зориулалтаар ашиглалтанд хэдийнэ нэвтэрсэн байх.

### 4-р зүйл. Гомоген байдал

Үржлийн онцлогоос шалтгаалан үүсч болох зөрүүг эс тооцвол ялгагдах гол шинж тэмдэгүүд нь хангалттай төвшинд жигд илэрч байвал уг сортыг гомоген гэж үзнэ.

### 5-р зүйл. Тогтвортой байдал

Ялгагдах гол шинж тэмдэгүүд нь үржүүлэг бүрийн дараа буюу циклээр үржүүлэх тохиолдолд үржүүлгийн цикл бүрийн дараа өөрчлөгдөлгүй илэрч байвал уг сортыг тогтвортой гэж үзнэ.

### 6-р зүйл. Шинэлэг байдал

(1) Хэрэв тухайн сортын ургамал буюу ургамлын эд эрхтнийг эрх бүхий этгээдийн эсхүл түүний өмнөх эрх бүхий этгээдийн зөвшөөрөлтэйгээр, мэдүүлэг гаргасан өдрийг хүртэл арилжааны зорилгоор бусдад дамжуулаагүй, эсхүл мэдүүлэг гаргасан өдрийг хүртэлх дараахь хугацаанд багтаан арилжааны зорилгоор бусдад дамжуулсан бол уг сортыг шинэ гэж үзнэ:

1. Европын Холбооны нутаг дэвсгэр дотор 1 жил,
2. Европын Холбооны нутаг дэвсгэрээс гадна 4 жил, усан үзэм (*Vitis L.*) ба модны зүйлүүдэд 6 жил.

(2) Бусдад дамжуулах дараахь тохиолдлуудад сортын шинэлэг байдал хөндөгдөхгүй:

1. Хуулийн зохицуулалтад үндэслэн төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх,
2. Эрх бүхий этгээдийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ буюу эрх зүйн бусад харьцаанд үндэслэн зөвхөн эрх бүхий этгээдийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэх, үржүүлэх, бэлтгэх буюу хадгалах зориулалтаар гуравдагч этгээдэд дамжуулах,
3. Европын Холбооны үйл ажиллагааны зарчмын тухай гэрээний 54-р зүйлийн 2-р заалтын дагуу, аль нэг нь нөгөөдөө харъяалагддаг буюу хоёул хамтдаа гуравдагч аж ахуйн нэгжид харъяалагддаг аж ахуйн нэгжүүдийн хооронд дамжуулах; энэ нь хоршоодод хамаарахгүй,
4. Түршилт судалгааны, эсхүл шинэ сортын селекцид ашиглах зориулалтаар бий болгосон ургамал буюу ургамлын эд эрхтнийг гуравдагч этгээдэд дамжуулах, ийнхүү дамжуулахдаа тухайн сортыг тусгайлан дурдаагүй байх,
5. 1928 оны 11 сарын 22-ны өдөр батлагдсан Олон улсын үзэсгэлэн, яармагийн тухай хэлэлцээрийн (1930 оны 5-р сарын 5-ны өдрийн хууль, RGBI<sup>2</sup>. 1930 II х. 727) дагуу албан ёсны буюу албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн үзэсгэлэнд үзүүлэх, эсхүл ижил статусаар аль нэг гэрээт улсын нутаг дэвсгэрт зохиогдсон үзэсгэлэнд үзүүлэх, эсхүл дээрх төрлийн үзэсгэлэнд үзүүлэх зорилгоор бусдад дамжуулах.

(3) Хэрэв нэг сортын үржлийн материал өөр сортын үржүүлэгт тогтмол ашиглагддаг бол зөвхөн хоёр дахь сортын ургамал буюу ургамлын эд эрхтнийг бусдад дамжуулсан тохиолдолд эхний

<sup>2</sup>Райхын Төрийн мэдээлэл.

сортын үржүүлгийн материалыг 1-р заалтын дагуу бусдад дамжуулсан гэж үзнэ.

### **7-р зүйл.Сортын оноосон нэр**

(1) Энэ зүйлийн 2-р буюу 3-р заалтад дурдагдсан үл зөвшөөрөх үндэслэл байхгүй тохиолдолд сортын оноосон нэрийг бүртгэж болно.

(2) Сортын оноосон нэр дараахь нөхцлүүдийг хангаж байвал энэ нь тухайн нэрийг үл зөвшөөрөх шалтгаан болно. Үүнд:

1. тухайн сортыг нэрлэхэд, ялангуяа хэллэгийн хувьд, тохиромжгүй,
2. ялгагдахуйц бус,
3. зөвхөн тоонуудаас бүрдэх;тухайн сорт зөвхөн өөр сортын үржүүлэгт ашиглагддаг бол үүнийг зөвшөөрч болно,
4. ижил буюу ойролцоо төрөл зүйлийн ургамлын ижил буюу андуурагдахуйц нэртэй сорт аль нэг гэрээт улсад буюу холбооны аль нэг гишүүний гаргасан мэдүүлгийн дагуу сортын албан жагсаалтад бүртгэгдсэн буюу бүртгэгдэж байсан, эсхүл тэрхүү сортын үржүүлгийн материал ашиглалтад нэвтэрсэн байх; энэхүү нөхцөл нь бүртгэлээс хасагдаж, таригдахаа больсон бөгөөд оноосон нэр нь төдийлөн ач холбогдолгүй болсон сортод хамаарахгүй,
5. төөрөгдүүлэх магадлалтай, ялангуяа сортын гарал үүсэл, шинж чанарууд, үнэ цэнэ, эсхүл зохиогч, нээгч буюу бусад эрх бүхий этгээдийн талаар буруу ойлголт өгөхүйц,
6. гомдол, маргаан үүсгэх магадлалтай.

Энэ заалтын 4-т дурдсан “ойролцоо төрөл зүйл”-д ямар төрөл зүйлүүдийг хамруулж үзэх талаар Холбооны Сортын Албанаас мэдээлнэ.

(3) Сорт хэдийнэ

1. өөр гэрээт улсад буюу холбооны аль нэг гишүүний гаргасан хүсэлтээр, эсхүл
2. Европын Хамтын Нийгэмлэгийн буюу Европын Холбооны эрх зүйн актанд Холбооны Сортын Албанаас гаргасан дүгнэлтээр, ургамлын сортуудыг Сортын хамтын каталогийн тухай журмуудад дүйцэхүйц дүрэм журмуудаар магадлан үнэлдэг өөр улсад

сортын албан жагсаалтанд бүртгэгдсэн эсхүл иймэрхүү жагсаалтад бүртгүүлэх хүсэлт тавигдсан бол зөвхөн тэнд бүртгэгдсэн буюу өгөгдсөн оноосон нэрээр уг сортыг бүртгэж болно. Энэ журам нь 2-р заалтын дагуу үл зөвшөөрөх шалтгаан үүссэн үед, эсхүл мэдүүлэг гаргагчийн нотолсноор аль нэг гуравдагч этгээдийн эрхийг хөндөх тохиолдолд үйлчлэхгүй.

### **8-р зүйл.Сорт хамгааллын эрх эзэмших эрх**

(1) Сортын зохиогч буюу нээгч, эсхүл түүний дараах эрх бүхий этгээд тухайн сортыг хамгааллын эрхийг эзэмших эрхтэй. Сортыг хамтран зохиосон буюу нээсэн бол уг эрхийг хамтран эдэлнэ.

(2) Мэдүүлэг гаргагч нь сорт хамгааллын эрх эзэмших эрхгүй болох талаар Холбооны Сортын Албанд мэдээлэл ирснээс бусад тохиолдолд Холбооны Сортын албанаас мэдүүлэг гаргагчийг эрх бүхий этгээд гэж үзнэ.

### **9-р зүйл. Зохих эрхгүй мэдүүлэг гаргагч**

(1) Зохих эрхгүй этгээд сорт хамгааллын эрх эзэмшихээр мэдүүлэг гаргасан бол эрх бүхий этгээд мэдүүлэг гаргагчаас сорт хамгаалуулах мэдүүлэг гаргах эрхийг шилжүүлэн өгөхийг шаардаж болно.

(2) Зохих эрхгүй этгээдэд сорт хамгааллын эрх олгогдсон бол эрх бүхий этгээд сорт хамгааллын эрхийг өөрт нь шилжүүлэн өгөхийг шаардах эрхтэй. Сорт хамгааллын эрх эзэмшигч уг эрхийг шударга бусаар авснаас бусад тохиолдолд уг шаардлага тавих эрх тухайн сорт хамгаалагдсан сортын жагсаалтад бүртгэгдсэнийг мэдээлснээс хойш таван жилийн дараа хүчингүй болно.

### **10-р зүйл. Сорт хамгааллын эрхийн үйлчлэх хүрээ**

(1) Энэ хуулийн 10а ба 10b дугаар дэд зүйлээр хязгаарлагдах сорт хамгааллын эрх нь эзэмшигчдээ дангаар эдлэх дараахь эрхийг олгоно. Үүнд:

1. Хамгаалагдсан сортын үржүүлгийн материалыг
  - a) үйлдвэрлэх, үржүүлгийн зориулалтаар бэлтгэх, ашиглах, импорлох буюу экспорлох, эсхүл
  - b) а-д дурдсан аль нэг зориулалтаар хадгалах.
2. Сорт хамгааллын эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр буюу сорт хамгааллын эрхээ эдлэх боломжгүй нөхцөлд хамгаалагдсан сортын үржүүлгийн материал ашиглан ургамал, ургамлын эд эрхтэн буюу бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол эдгээрийг 1-д дурдсан үйл ажиллагаанд ашиглах.

(2) 1-р заалтад дурдагдсан сорт хамгааллын эрх түүнчлэн дараахь сортуудад үйлчилнэ. Үүнд:

1. хэрэв хамгаалагдсан сорт нь өөрөө хоёрдогч сорт биш бол хамгаалагдсан сортоос (анхдагч сортоос) гарган авсан хоёрдогч сортууд,
2. хамгаалагдсан сортоос илэрхий ялгагдахгүй сортууд,
3. хамгаалагдсан сортыг тогтмол ашиглах замаар үйлдвэрлэгддэг сортууд.

(3) Дараахь сортыг хоёрдогч сорт гэж үзнэ. Үүнд:

1. анхдагч сорт буюу түүнээс гарган авсан өөр хоёрдогч сортыг селекцийн эх материал болгон ашиглах замаар гарган авсан,
2. бусад сортоос илэрхий ялгагдахуйц бөгөөд
3. тухайн сортын селекцид ашигласан аргачлалаас хамааран үүсэх ялгааг эс тооцвол анхдагч сортын генотип буюу генотипийн бүрдлийн үүсгэх шинж тэмдэгүүдийн илрэл нь анхдагч сортынхтой үндсэндээ тохирох сорт.

### **10а-р зүйл. Сорт хамгааллын эрхийн үйлчлэх хүрээний хязгаарлалт**

(1) Сорт хамгааллын эрх нь энэ хуулийн 10-р зүйлийн 1-р заалтад дурдагдсан үйл ажиллагаанд дараахь тохиолдолд үйлчлэхгүй. Үүнд:

1. арилжааны бус зориулалтаар хувийн хэрэгцээнд ашиглах,
2. хамгаалагдсан сорттой холбоотой туршилт, судалгаанд ашиглах,
3. шинэ сортын селекцид ашиглах, түүнчлэн 10-р зүйлийн 2-р заалтад дурдагдсанаас бусад тохиолдолд тэдгээр шинэ сортуудыг 10-р зүйлийн 1-р заалтад дурдагдсан үйл ажиллагаанд ашиглах.

(2) Түүнчлэн энэ хуулийн хавсралтад жагсаасан төрөл зүйлүүдийн, гибрид ба синтетик сортуудаас бусад хамгаалагдсан сортын үржүүлгийн материалыг тариалан эрхлэгч өөрийн аж ахуйд тариалж, ургацыг тариалалтад эргүүлэн ашиглах тохиолдолд, хэрэв тухайн тариалан эрхлэгч энэ зүйлийн 3 ба 6-р заалтаар хүлээсэн үүргээ биелүүлбэл, тариалалтад эргүүлэн ашиглах ургацад сорт хамгааллын эрх үйлчлэхгүй. Ургацыг тариалалтад ашиглах зорилгоор тухайн тариалан эрхлэгч өөрөө буюу түүний захиалгаар өөр аж ахуйн нэгж бэлтгэж болно.

(3) Хамгаалагдсан сортын ургацыг тариалалтад эргүүлэн ашиглах тохиолдолд тариалан эрхлэгч сортын хамгааллын эрх эзэмшигчид зохистой хэмжээний хураамж төлөх үүрэгтэй. Хэрэв уг хураамж нь тухайн сортын үржүүлгийн материалыг тухайн орон нутагт энэ хуулийн 11-р зүйлд дурдагдсан ашиглалтын эрхийн дагуу үржүүлэхэд ногдуулсан хураамжаас илэрхий доогуур байвал түүнийг зохистой хэмжээнд байна гэж үзнэ.

(4) Тариалан эрхлэгчээс сорт хамгааллын эрх эзэмшигчид төлөх хураамжийн хэмжээг талууд харилцан тохиролцохдоо тал тус бүрийг төлөөлөх мэргэжлийн холбоодын хооронд үйлдэгдсэн зохих хэлэлцээрүүдийг үндэслэж болно. Уг тохиролцоо нь үрийн аж ахуйн салбар дахь өрсөлдөөнийг ямар нэг байдлаар үгүйсгэж үл болно.

(5) Энэ зүйлийн 3-р заалтад дурдагдсан төлбөрийн хариуцлага нь Европын Холбооны Зөвлөлийн

1994 оны 7-р сарын 27-ны өдрийн (EG) 2100/94 тоот “Европын Хамтын Нийгэмлэгийн Сорт Хамгааллын Журам”-ын (ABl. EG д. L 227 х. 1)<sup>3</sup> 14-р зүйлийн 3-р заалтын 3-д тодорхойлсон“ жижиг фермерүүд”-эд хамаарахгүй.

(6) Хамгаалагдсан сортын ургацыг тариалалтад эргүүлэн ашиглах тохиолдолд тариалан эрхлэгч өөрөө буюу түүний захиалгаар ургацыг тариалалтад бэлтгэх үүрэг хүлээсэн аж ахуй нэгж нь тариалалтын хэмжээний талаар сорт хамгааллын эрх эзэмшигчид мэдээлэх үүрэгтэй.

(7) Холбооны Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам шаардлагатай тохиолдолд энэ хуулийн хавсралт дахь таримал ургамлын төрөл зүйлийн жагсаалтыг Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгаалалд хамаарах жагсаалтад нийцүүлэн өөрчлөх тухай тогтоол, журмыг гаргах эрхтэй.

### **10b-р зүйл. Сорт хамгааллын эрхүйлчлэхгүй байх**

Хамгаалагдсан сортын, эсхүл энэ хуулийн 10-р зүйлийн 1-р заалтын 1-ийн дагуу сорт хамгаалалд хамрах ямар нэг сортын ургамал, ургамлын эд эрхтэн буюу тэдгээрээс гарган авсан бүтээгдэхүүнийг (материалыг) сорт хамгааллын эрх эзэмшигч өөрөө эсхүл түүний зөвшөөрөлтэйгээр ашиглах тохиолдолд сорт хамгааллын эрх үйлчлэхгүй. Гэхдээ энэхүү заалт нь дараахь тохиолдолд хүчингүй:

1. тухайн материалыг үржүүлгийн материал үйлдвэрлэхээс өөр зориулалтаар бусдад дамжуулсан боловч үржүүлгийн материал үйлдвэрлэсэн тохиолдолд, эсхүл
2. сортын үржүүлэгт ашиглагдах боломжтой материалыг тухайн ургамлын сортуудад эрхийн хамгаалалт үзүүлдэггүй улсад тариалалтаас бусад зориулалтаар экспортлох тохиолдолд.

### **10с-р зүйл. Сорт хамгааллын эрхийг түдгэлзүүлэх**

Энэ хуулийн дагуу олгогдсон сорт хамгааллын эрх эзэмшигчид тухайн хамгаалагдсан сортод хамаарах Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгааллын эрх давхар олгогдох тохиолдолд Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгааллын эрх хүчинтэй байх хугацаанд энэ хуулийн дагуу олгогдсон сорт хамгааллын эрх үйлчлэхгүй.

### **11-р зүйл. Эрх шилжүүлэх, Ашиглалтын эрх**

(1) Сорт хамгааллын эрх эзэмших эрх, сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргах эрх болон сорт хамгааллын эрхийг энэ хуулийн 15-р зүйлд дурдагдсан нөхцлүүдийг биелүүлсэн хувь хүн, хуулийн этгээд, арилжааны түншлэлд шилжүүлж болно.

(2) Сорт хамгааллын эрхийг бүхлээр нь эсхүл хэсэгчилсэн байдлаар дангаар буюу дангаар бус ашиглалтын эрхэд хамруулж болно.

(3) Ашиглалтын эрх эзэмшигч энэ зүйлийн 2-р заалтад дурдагдсан ашиглалтын эрхийн ямар нэг хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд тухайн этгээдэд сорт хамгааллын эрхийн дагуу хориг арга хэмжээ авч болно.

### **12-р зүйл. Сорт албадан ашиглах эрх**

(1) Сорт хамгааллын эрх эзэмшигч ашиглалтын эрх олгохгүй буюу хангалтгүй хэмжээнд олгох тохиолдолд Холбооны Сортын Албанд ирүүлсэн хүсэлтэд үндэслэн түс албанаас нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор, сорт хамгааллын эрх эзэмшигчид үчрах эдийн засгийн үр дагаврыг харгалзан үзсэний үндсэн дээр, энэ хуулийн 10-р зүйлтэй холбогдуулан тухайн сортыг албадан ашиглах эрхийг зохих нөхцлүүдээр олгож болно. Холбооны Сортын Албанаас албадан ашиглах эрх олгохдоо нөхцлүүдийг нь зааж өгөх бөгөөд үүнд ялангуяа сорт хамгааллын эрх эзэмшигчид төлөх хураамжийн хэмжээг тогтооно.

(2) Сорт албадан ашиглах эрх олгосноос нэг жилийн дараа холбогдох аль нэг талын зүгээс ашиглалтын нөхцлүүдийг шинэчлэх хүсэлт гаргаж болно. Уг хүсэлтийг жил тутам шинээр гаргаж

<sup>3</sup>ABl. EG = Европын Холбооны Төрийн мэдээлэл, L = тогтоол, журам, шийдвэр, удирдамж зэрэг эрх зүйн баримт бичгүүд.

болно; гэхдээ энэ нь сорт ашиглалтад нөлөөлөх нөхцөл байдлын бодитой өөрчлөлтөд үндэслэсэн байх шаардлагатай.

(3) Сорт албадан ашиглах эрх олгох, шинэчлэх тухай шийдвэр гаргахынхаа өмнө Холбооны Сортын Алба холбогдох нэгдсэн (дээвэр) холбоодоос санал авна.

(4) Үр ашиглах тухай хуулийн зохицуулалтад хамаарах ургамлын аль нэг төрөл зүйлийн сортыг албадан ашиглах эрх олгогдсон бол тухайн сортын хамгааллын эрх эзэмшигч холбогдох албан байгууллагаас дараах мэдээллийг шаардах эрхтэй. Үүнд:

1. хамгаалагдсан сортын үржүүлгийн материал дүр баталгаажуулах хүсэлт гаргасан этгээд,
2. тухайн хүсэлтэд өгөгдсөн үржүүлгийн талбайн хэмжээ,
3. үйлдвэрлэх үрийн багцын тоо ширхэг, багц тус бүрийн жин.

### **12а-р зүйл. Биотехнологийн нээлт ашиглах зориулалтаар сорт албадан ашиглах эрх**

(1) Биотехнологийн нээлтийн патент эзэмшигч (Патентийн тухай хуулийн 1-р зүйлийн 2-р заалт) үүнийгээ өмнө нь олгогдсон сорт хамгааллын эрхийг хөндөлгүйгээр ашиглах боломжгүй тохиолдолд Холбооны Сортын Албанаас хүсэлтийн дагуу энэ хуулийн 3 ба 4-р зүйлийг үндэслэн, энэ хуулийн 10-р зүйлд холбогдуулан тухайн сортыг албадан ашиглах эрхийг зохистой нөхцлүүдээр олгоно.

(2) Сорт хамгааллын эрх эзэмшигч патент эзэмшигчээс харилцан ашиглах лиценз<sup>4</sup> зохистой нөхцлүүдээр эзэмшүүлэхийг шаардаж болно.

(3) Патент эзэмшигч нь дараахь нөхцлүүдийг нотлох шаардлагатай. Үүнд:

1. хамгаалагдсан сортыг ашиглах эрхийг сорт хамгааллын эрх эзэмшигчээс хүссэн боловч хүсэлтийг нь хүлээн аваагүй тухай,
2. тухайн биотехнологийн нээлт нь тухайн хамгаалагдсан сорттой харьцуулахад эдийн засгийн ихээхэн ач холбогдол бүхий технологийн томоохон дэвшил болох тухай.

(4) Холбооны Сортын Албанаас сорт албадан ашиглах эрх олгохдоо нөхцлүүдийг нь тодорхой зааж өгөх бөгөөд үүнд ялангуяа сорт хамгааллын эрх эзэмшигчид төлөх хураамжийн хэмжээг тогтооно. Энэ хуулийн 12-р зүйлийн 2 ба 4-р заалтуудыг нийцүүлэн хэрэглэнэ.

### **13-р зүйл. Сорт хамгааллын эрхийн хүчинтэй хугацаа**

Сорт хамгааллын эрхийн үйлчлэх хугацаа тус эрхийг эзэмшүүлснээс хойших хорин тав дахь, зөрөг цэцэг, төмс, усан үзэм ба модны зүйлүүдэд гуч дахь хуанлийн жилийн эцэс хүртэл үргэлжилнэ.

### **14-р зүйл. Сортын оноосон нэрийг ашиглах**

(1) Хамгаалагдсан сортын үржүүлгийн материалыг арилжааны бус зориулалтаар хувийн хэрэгцээнд ашиглахаас бусад тохиолдолд ашиглахдаа тухайн сортын оноосон нэрийг заавал зааж өгнө; бичиглэсэн заалтад бичиглэл нь хялбархан танигдахуйц, гаргацтай байна. Энэ заалт сорт хамгааллын эрхийн хүчинтэй хугацаа дууссаны дараа ч мөрдөгдөнө.

(2) Сортын оноосон нэртэй ижил нэрийг эзэмших эрх нь уг сортын оноосон нэрийг ашиглахыг хориглох нөхцөл үүсгэхгүй. Гуравдагч этгээдийн нэгэнт эзэмшиж буй эрх энд хөндөгдөхгүй.

(3) Хамгаалагдсан сортын, эсхүл холбооны аль нэг гишүүнээс сорт зохиогчийн эрх олгосон аль нэг сортын оноосон нэр эсхүл түүнтэй андуурагдахуйц нэрийг ижил буюу ойролцоо төрөл зүйлийн ургамлын өөр сортод хэрэглэхийг хориглоно.

### **15-р зүйл. Сорт хамгааллын эрх эзэмших субъект**

(1) Энэ хуулиар зохицуулагдах сорт хамгааллын эрхийг зөвхөн дараахь субъектуудад олгоно:

<sup>4</sup>Биотехнологийн нээлтийн патент эзэмшигч хамгаалагдсан сорт ашигласны хариуд сорт хамгааллын эрх эзэмшигч зөрүүлээд тухайн биотехнологийн нээлтийг ашиглах лиценз.

1. Үндсэн хуулийн 116-р зүйлийн 1-р заалтад дурдагдсан нөхцлийг хангах Герман улсын иргэд, Герман улсад оршин суудаг хувь хүн буюу тус улсад байршилтай хуулийн этгээд, арилжааны түншлэл;
  2. Аль нэг гэрээт улсын буюу холбооны гишүүн улсын иргэд ба тухайн улсад оршин суудаг буюу байршилтай хувь хүн, хуулийн этгээд, арилжааны түншлэл; мөн
  3. Энэ хуулиар зохицуулагдах сорт хамгааллын эрхтэй дүйцэхүйц эрхийг Герман улсын иргэд ба Герман улсад оршин суудаг буюу байршилтай иргэд, хуулийн этгээдэд олгодог тухай Холбооны Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамнаас Холбооны улсын Төрийн мэдээлэлд танилцуулсан аль нэг улсын харъяа иргэд, эсхүл тус улсад оршин суудаг буюу байршилтай хувь хүн, хуулийн этгээд, арилжааны түншлэл.
- (2) Гэрээт улсад оршин суудаггүй буюу байршилгүй этгээд зөвхөн аль нэг гэрээт улсад оршин суудаг буюу ажлын байр нь байрладаг төлөөлөгчөөр (итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр) дамжуулан энэ хуулиар зохицуулагдах эрх зүйн харилцаанд оролцох буюу энэ хуулиар зохицуулагдах эрхийг эдэлж болно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **Холбооны Сортын Алба**

#### **16-р зүйл. Статус ба үүрэг**

- (1) Холбооны Сортын Алба нь Холбооны Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамны чиг үүргийн хүрээнд бие даасан үйл ажиллагаа эрхэлдэг Холбооны төрийн захиргааны дээд байгууллага мөн.
- (2) Холбооны Сортын алба нь сорт хамгааллын эрх олгох, үүнтэй холбогдох асуудлуудыг хариуцна. Тус Алба нь хамгаалагдсан сортын жагсаалтыг хөтлөх ба хамгаалагдсан сортууд сортын онцлог шинж чанараа хэвээр хадгалж буй эсэхэд хяналт тавина.

#### **17-р зүйл. Гишүүд**

- (1) Холбооны Сортын Алба нь Ерөнхийлөгч болон гишүүдээс бүрдэнэ. Эдгээр нь таримал ургамлын сортын чиглэлээр мэргэшсэн (мэргэжлийн гишүүд) эсхүл Герман улсын Шүүгчийн тухай хуулийн дагуу шүүх албанд томилогдох эрхийг хангасан хүмүүс (хуульч гишүүд) байна. Гишүүдийг Холбооны Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамнаас Холбооны Сортын Албанд ажиллуулахаар тодорхой хугацаагаар томилно.
- (2) Онцгой нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд Холбооны Сортын Албандажиллахад нийцэх байгалийн шинжлэх ухааных дээд сургуульд суралцан дотоодод төгсөлтийн шалгалтандаа тэнцэж дээд боловрол эзэмшсэн, эсхүл үүнтэй дүйцэх төвшний зэрэг олгох гадаадын их дээд сургуулийг төгссөн, гурваас цөөнгүй жил холбогдох мэргэжлийнсалбарт ажилласан бөгөөд эрх зүйн зохих мэдлэгтэй хүнийг мэргэжлийн гишүүнээр томилно.
- (3) Урьдчилсан байдлаар тодорхой хугацаанд хүн хүчний хэрэгцээ үүссэн нөхцөлд Ерөнхийлөгчийн зүгээс Холбооны Сортын Албаны гишүүдийн ажил үүргийг гүйцэтгүүлэхээр туслах гишүүд гэрээгээр ажиллуулж болно. Гэрээг урьдчилан тодорхойлсон хугацаанд буюу тухайн хүн хүчний хэрэгцээ үргэлжлэх хугацаанд хүчинтэй байхаар үйлдэж болох бөгөөд энэ хугацаанд уг гэрээг цуцлах боломжгүй. Гишүүдэд үйлчлэх дүрэм, журмууд туслах гишүүдэд ижилхэн үйлчилнэ.

#### **18-р зүйл. Сорт сорилтын хэлтсүүд ба Маргаан шийдвэрлэх хороод**

- (1) Холбооны Сортын Албанд:
    1. Сорт сорилтын хэлтсүүд,
    2. Сорт хамгааллын эрхтэй холбоотой Маргаан шийдвэрлэх хороодыг байгуулна.
- Ерөнхийлөгч эдгээрийн тоог баталж, ажлын хуваарилалтыг зохицуулна.



(2) Сорт сорилтын хэлтсүүд нь дараахь асуудлуудаар шийдвэр гаргах үүрэгтэй. Үүнд:

1. Сорт хамгааллын эрх эзэмшихээр гаргасан мэдүүлгийг шийдвэрлэх,
2. Энэ хуулийн 25-р зүйлийн дагуу гаргасан эсэргүүцлийг шийдвэрлэх,
3. Энэ хуулийн 30-р зүйлийн дагуу сортын оноосон нэрийг өөрчлөх,
4. (хасагдсан)
5. Сорт албадан ашиглах эрх олгох, нөхцлүүдийг тодорхойлох,
6. Сорт хамгааллын эрхийг хураах, цуцлах.

(3) Маргаан шийдвэрлэх хороод нь Сорт сорилтын хэлтсүүдээс гаргасан шийдвэрүүдтэй холбогдуулан гаргасан гомдлуудыг шийдвэрлэх үүрэгтэй.

### **19-р зүйл. Сорт сорилтын хэлтэсүүдийн бүрэлдэхүүн**

(1) Сорт сорилтын хэлтэс тус бүр Ерөнхийлөгчийн томилсон Холбооны Сортын Албаны мэргэжлийн нэг гишүүнээс бүрдэнэ.

(2) Энэ хуулийн 18-р зүйлийн 2-р заалтын 2, 5 ба 6-д дурдагдсан тохиолдлуудад Сорт сорилтын хэлтэс Ерөнхийлөгчийн томилсон Холбооны Сортын Албаны гурван гишүүний, үүнд нэг хуульч гишүүн багтсан байх, бүрэлдэхүүнтэйгээр шийдвэр гаргана.

### **20-р зүйл. Маргаан шийдвэрлэх хороодын бүрэлдэхүүн**

(1) Маргаан шийдвэрлэх хороо тус бүрийг Ерөнхийлөгч өөрөө буюу түүний томилсон Холбооны Сортын Албаны нэг гишүүн даргалж, Холбооны Сортын Албаны гишүүдээс Ерөнхийлөгчийн томилсон орон тооны хоёр шинжээч, түүнчлэн орон тооны бус хоёр шинжээч ажиллана. Хороо бүрт ажиллах Холбооны Сортын Албаны гишүүдийн хоёр нь мэргэжлийн гишүүн, нэг нь хуульч гишүүн байна.

(2) Орон тооны бус шинжээчдийг Холбооны Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамнаас зургаан жилийн хугацаатай томилох ба улираан томилж болно. Орон тооны бус шинжээч хугацаанаасаа өмнө хорооноос гарах тохиолдолд түүний ажиллах үлдсэн хугацаанд өөр хүн томилж ажиллуулна. Орон тооны бус шинжээчид нь таримал ургамлын сортын чиглэлээр өндөр төвшинд мэргэшсэн байна. Ургамлын селекцийн чиглэлээр ажилладаг аж ахуйн нэгжийн эзэд буюу ажилтнууд эсхүл ургамлын селекцийн мэргэжлийн холбоодын ажилтнуудыг орон тооны бус шинжээчээр томилохгүй. Орон тооны бус шинжээч бүрт нэг орлогч томилно; орлогчдод энэ заалтын 1-ээс 4 дэх өгүүлбэрүүдийг нийцүүлэн хэрэглэнэ.

(3) Маргаан шийдвэрлэх хороод нь дарга, нэг орон тооны шинжээч, нэг орон тооны бус шинжээчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэр гаргах эрхтэй бөгөөд дарга ба орон тооны зөвлөхийн аль нэг нь хуульч гишүүн байх ёстой.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **Холбооны Сортын Албаны үйл ажиллагааны журам**

#### **21-р зүйл. Захиргааны албан хэргийг ёсчлон гүйцэтгэх журам**

Сорт сорилтын хэлтсүүд ба Маргаан шийдвэрлэх хороодын үйл ажиллагаанд Захиргааны албан хэрэг гүйцэтгэх тухай хуулийн 63-с 69-р зүйл, түүнчлэн 71-р зүйлд заагдсан захиргааны албан хэргийг ёсчлон гүйцэтгэх тухай журмуудыг хэрэглэнэ.

#### **22-р зүйл. Сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг**

(1) Мэдүүлэг гаргагч мэдүүлэгтээ сортын зохиогчийн буюу нээгчийн нэрийг зааж өгөх ба өөрийн мэдэж буйгаар уг сортын селекци буюу нээлтэд өөр хүмүүс нэмж оролцоогүй болохыг батлан мэдүүлсэн байна. Мэдүүлэг гаргагч нь сортын зохиогч буюу нээгч биш, эсхүл дангаар биш бол

сортыг хэрхэн олж авснаа мэдүүлнэ. Холбооны Сортын Алба уг мэдээллийг шалгах үүрэг хүлээхгүй.

(2) Мэдүүлэг гаргагч мэдүүлэгтээ сортын оноосон нэрийг тодорхойлно. Сорт хамгааллын эрх олгох ажиллагаанд Холбооны Сортын Албаны зөвшөөрөлтөйгөөр сортын түр тэмдэглэгээ ашиглаж болно.

### **23-р зүйл. Сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлгийг хугацаагаар эрэмбэлэх**

(1) Сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлгийг хугацаагаар эрэмбэлэхдээ эргэлзээтэй тохиолдолд Холбооны Сортын Албаны бичиг хэрэгт бүртгэгдсэн огноог нь баримтална.

(2) Мэдүүлэг гаргагч мэдүүлэг гаргахаасаа өмнө холбооны аль нэг гишүүн улсад тухайн сортын зохиогчийн эрх авах мэдүүлэг гаргасан тохиолдолд, эхний мэдүүлгээ зохих журмын дагуу хүргүүлснээс хойших нэг жилийн хугацаанд тухайн этгээд эхний мэдүүлгийнхээ хугацааны эрэмбийг сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэгтээ тооцуулах хугацааны давуу эрх эдэлнэ. Хугацааны давуу эрх нь зөвхөн сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэгт хамаарна. Хэрэв мэдүүлэг гаргагч мэдүүлэг гаргасан өдрөөс хойш гурван сарын дотор эхний мэдүүлэг, холбогдох бичиг баримтын, тухайн мэдүүлгийг хүлээн авсан албан байгууллагаар баталгаажуулсан хуулбарыг Холбооны Сортын Албанд ирүүлээгүй бол хугацааны давуу эрх хүчингүй болно.

(3) Сортын оноосон нэр нь мэдүүлэг гаргагчийн эзэмших, тухайн сортын үржүүлгийн материалыг хамрах барааны тэмдэгээр Патентийн албанд бүртгэгдсэн эсхүл бүртгүүлэх хүсэлт нь хүргэгдсэн тохиолдолд тухайн этгээдэд уг барааны тэмдэгийг бүртгүүлсэн буюу бүртгүүлэх хугацааны эрэмбийг сортын оноосон нэрийг бүртгүүлэх хугацаанд тооцуулах давуу эрх эдэлнэ. Хэрэв мэдүүлэг гаргагч сортын оноосон нэрийг бүртгүүлэх хүсэлт гаргасан өдрөөсөө хойш гурван сарын дотор тус барааны тэмдэгийг бүртгүүлсэн буюу бүртгүүлэхээр хүсэлт гаргасан тухай Патентийн албаны тодорхойлолтыг Холбооны Сортын Албанд ирүүлээгүй бол хугацааны давуу эрх хүчингүй болно. Энэхүү заалтын 1 ба 2-р өгүүлбэрт заагдсан журмуудыг Барааны тэмдэгийн олон улсын бүртгэлийн тухай 1891 оны 4-р сарын 14-ний Мадридын гэрээний тухайн бүрийн хүчинтэй найруулгын дагуу олон улсад бүртгэгдсэн, дотоодод хамгаалагдсан барааны тэмдэгүүдэд нийцүүлэн хэрэглэнэ.

### **24-р зүйл. Сорт хамгаалах эрх эзэмших мэдүүлгийг олон нийтэд мэдээлэх**

(1) Холбооны Сортын Албанаас сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлгийг, тухайн ургамлын төрөл зүйл, сортын оноосон нэр буюу түр тэмдэглэгээ, мэдүүлэг гаргасан огноо, түүнчлэн мэдүүлэг гаргагч, сортын зохиогч буюу нээгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, хаягийг багтаасан мэдэгдлээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

(2) Мэдүүлгийг олон нийтэд мэдээлсний дараа буцаан татсан, эсхүл мэдүүлгийг энэ хуулийн 27-р зүйлийн 2-р заалтын дагуу хугацаа хоцроосон үндэслэлээр Холбооны Сортын Алба хүлээн аваагүй, эсхүл сорт хамгааллын эрх олгохоос татгалзсан бол Холбооны Сортын албанаас үүнийг мөн олон нийтэд мэдээлнэ.

### **25-р зүйл. Эсэргүүцэл**

(1) Сорт хамгаалах эрх олгох тухай шийдвэрийн эсрэг Холбооны Сортын Албанд эсэргүүцэл гаргах эрх хэн бүхэнд нээлттэй.

(2) Эсэргүүцэл нь зөвхөн дараахь үндэслэлүүдэд суурилна. Үүнд:

1. тухайн сорт ялгагдахуйц бус, гомоген бус, тогтвортой бус эсхүл шинэлэг бус,
2. мэдүүлэг гаргагч зохих эрхгүй, эсхүл
3. сортын оноосон нэрийг бүртгэх боломжгүй.

(3) Эсэргүүцэл гаргахад дараахь хугацааг баримтална. Үүнд:

1. Энэ зүйлийн 2-р заалтын 1-д заагдсан үндэслэлээр эсэргүүцэл гаргахад сорт хамгааллын эрх олгох хүртэл хугацаанд,

2. Энэ зүйлийн 2-р заалтын 2-т заагдсан үндэслэлээр эсэргүүцэл гаргахад сорт хамгаалах эрх эзэмших мэдүүлгийг олон нийтэд мэдээлснээс хойш гурван сарын дотор,
  3. Энэ зүйлийн 2-р заалтын 3-т заагдсан үндэслэлээр эсэргүүцэл гаргахад сортын оноосон нэрийг нийтэд мэдээлснээс хойш гурван сарын дотор.
- (4) Эсэргүүцэл нь бодит үндэслэлтэй байна. Энэ зүйлийн 2-р заалтад дурдагдсан үндэслэлийг бүрдүүлэх баримт, нотолгоог нэг бүрчлэн мэдүүлнэ. Эдгээрийг эсэргүүцэлд анхнаасаа мэдүүлээгүй бол эсэргүүцэл гаргах хугацаанд багтаан нөхөн ирүүлж болно.
- (5) Энэ зүйлийн 2-р заалтын 2-т заагдсан үндэслэлээр гаргасан эсэргүүцлийн дагуу сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлгийг буцаан татсан эсхүл сорт хамгааллын эрх олгохоос татгалзсан тохиолдолд мэдүүлгийг буцаан татсанаас хойш эсхүл татгалзсан шийдвэр маргашгүй болсноос хойш нэг сарын дотор эсэргүүцэл гаргагч этгээд тухайн сортын хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргавал эхний мэдүүлэг гаргасан огноог өөрийн гаргасан мэдүүлэгтээ тооцуулахыг нэхэмжлэх эрхтэй.

### **26-р зүйл.Сорт сорилт**

- (1) Аливаа сорт сорт хамгааллын эрх олгоход тавигдах шаардлагуудад нийцэж буй эсэхийг Холбооны Сортын Алба сорихдоо тухайн сортыг тариалах буюу эсхүл бусад шаардлагатай судалгааг гүйцэтгэнэ. Холбооны Сорилтын Албанаас өмнө нь тухайн сортын сорилтыг гүйцэтгэсэн үр дүн бэлэн байх тохиолдолд дахин сорихоос татгалзаж болно.
- (2) Холбооны Сортын Алба сорт сорилтын тариаланг буюу эсхүл бусад шаардлагатай судалгааг дотоодын буюу гадаадын мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж, тэдгээр байгууллагуудаас гүйцэтгэсэн сорилтын тариалангийн эсхүл бусад холбогдох судалгааны үр дүнг авч ашиглаж болно.
- (3) Холбооны Сортын Алба нь мэдүүлэг гаргагчаас, Холбооны Сортын Албанд буюу тус Албанаас сорт сорилт гүйцэтгүүлэхээр заасан байгууллагад шаардлагатай үржүүлгийн ба бусад материал, холбогдох баримт бичгүүдийг тодорхой заасан хугацаанд багтаан ирүүлэх, шаардлагатай мэдээлэл лавлагаа өгөх, сорт сорилт гүйцэтгэхийг зөвшөөрөхийг шаардана.
- (4) Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 23-р зүйлийн 2-р заалтын дагуу хугацааны давуу эрх эдлэх тохиолдолд хугацааны давуу эрх эдлэх хугацаа дууссанаас хойш дөрвөн жилийн дотор багтаан шаардлагатай үржүүлгийн ба бусад материал, холбогдох баримт бичгүүдийг ирүүлнэ. Түүнээс хойш өөр үржүүлгийн материал болон бусад нэмэлт материал нөхөн ирүүлэх эрхгүй. Дөрвөн жилийн хугацаа дуусахаас өмнө эхний мэдүүлгийг буцаан татсан буюу сортын зохиогчийн эрх олгохоос татгалзсан тохиолдолд Холбооны Сортын Алба мэдүүлэг гаргагчаас, тариалалтын дараагийн мөчлөгт зориулан үржүүлгийн болон бусад материал ирүүлэхийг, түүнчлэн холбогдох баримт бичгүүдийг тодорхой тогтоосон хугацаанд багтаан ирүүлэхийг шаардах эрхтэй.
- (5) Холбооны Сортын Алба шаардлагатай гэж үзвэл харилцан мэдээлэл солилцох зорилгоор гадаадын албад, байгууллагуудад сорт сорилтын үр дүнгийн талаар мэдээлэл дамжуулж болно.
- (6) Холбооны Сортын Алба мэдүүлэг гаргагчаас дараахь мэдээллийг тодорхой заагдсан хугацаанд бичгээр ирүүлэхийг шаардана. Үүнд:
  1. хэрэв сортын нэршилд түр зуурын тэмдэглэгээ ашигласан бол сортын оноосон нэрийг,
  1. хэрэв сортын оноосон нэрийг мэдүүлсэн хувилбараар бүртгэх боломжгүй бол өөр оноосон нэрийг.

Энэ хуулийн 24 ба 25-р зүйлийн заалтыг нийцүүлэн хэрэглэнэ.

### **27-р зүйл.Хугацаа хоцроох**

- (1) Мэдүүлэг гаргагч Холбооны Сортын Албанаас тавьсан дараахь шаардлагыг, хэрэв уг шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд мэдүүлгийг нь хүлээн авахгүй байх үр дагаврыг хугацаа тогтоохдоо урьдчилан анхааруулсан байхад, заагдсан хугацаанд багтаан биелүүлээгүй бол Холбооны Сортын Алба сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлгийг хүлээж авахаас татгалзаж

болно. Үүнд:

1. шаардлагатай үржүүлгийн материал эсхүл бусад материал эсхүл холбогдох нэмэлт баримт бичгүүд ирүүлэх,
2. сортын оноосон нэрийг мэдүүлэх, эсхүл
3. сорт сорилтын хураамжийг төлөх.

(2) Хураамж төлөх шийдвэрийг Холбооны Сортын албанаас танилцуулж, шийдвэр биелүүлээгүй тохиолдолд үүсэх үр дагаврыг урьдчилан анхааруулснаас хойш нэг сарын дотор мэдүүлэг гаргагч эсхүл эсэргүүцэл гаргагч этгээд сорт хамгаалах эрх эзэмших мэдүүлгийг шийдвэрлэх буюу эсхүл эсэргүүцэл шийдвэрлэх хураамжийг төлөөгүй бол мэдүүлэг эхсүл эсэргүүцэл гаргаагүй гэж үзнэ.

### **28-р зүйл. Хамгаалагдсан сортын жагсаалт**

(1) Сорт хамгааллын эрх маргашгүй болох нь тогтоогдсоны дараа хамгаалагдсан сортын жагсаалтад дараахь мэдээллийг бүртгэнэ. Үүнд:

1. ургамлын төрөл зүйл ба сортын оноосон нэр,
2. сортын ялгагдах байдлыг илэрхийлэх гол шинж тэмдэгүүдийн тодорхойлогдсон илэрцүүд; удамшлын тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдийн эрлийзжүүлгээр үржүүлдэг сортуудын хувьд мөн холбогдох тайлбарыг,
3. дараахь этгээдийн нэр, хаяг:
  - а) сортын зохиогч буюу нээгч,
  - б) сортын хамгааллын эрх эзэмшигч,
  - в) итгэмжлэгдсэн төлөөлөгч,
4. сорт хамгааллын эрхийн үйлчлэх хугацаа эхэлсэн ба дууссан огноо, түүнчлэн дуусгавар болсон шалтгаан,
5. дангаар ашиглах эрх, уг эрхийг эзэмшигчийн нэр, хаяг,
6. албадан ашиглах эрх, түүнд заагдсан нөхцлүүд.

(2) Ялгагдах байдлыг илэрхийлэх гол шинж тэмдэгүүдийн тодорхойлогдсон илэрцүүдийн болон албадан ашиглах эрхийн нөхцлүүдийн бүртгэлийг Холбооны Сортын Албаны холбогдох баримт бичгүүдийг дурдах байдлаар орлуулж болно. Хэрэв Холбооны Сорт Алба тухайн сортын тодорхойлолтыг бусад сортуудын тодорхойлолттой харьцуулахад шаардлагатай гэж үзвэл гол шинж тэмдэгүүдийн тодорхойлогдсон илэрцүүдийн тоо, төрлийн талаар бүртгэлд өөрчлөлт оруулж болно.

(3) Сорт хамгааллын эрх эзэмшигч буюу итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрчлөгдөх тохиолдолд уг өөрчлөлтийг зөвхөн нотлох баримтыг үндэслэн бүртгэнэ. Өөрчлөлтийг бүртгэх хүртэл өмнө нь бүртгэгдсэн сорт хамгааллын эрх эзэмшигч буюу итгэмжлэгдсэн төлөөлөгч энэ хуулинд заагдсан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

(4) Бүртгэлийг Холбооны Сортын Алба олон нийтэд мэдээлнэ.

### **29-р зүйл. Нээлттэй үзлэг**

(1) Дараахь эрх хэн бүхэнд нээлттэй байна. Үүнд:

1. Хамгаалагдсан сортын жагсаалтыг үзэх,
2. Дараахь баримт бичгүүдийг үзэх:
  - а) энэ хуулийн 28-р зүйлийн 2-р заалтын 1-р өгүүлбэрт дурдагдсан баримт бичиг,
  - б) нийтэд мэдээлэгдсэн сорт хамгааллын эрх эзэмших хүсэлтийн болон олгогдсон сорт хамгааллын эрхийн баримт бичиг.
3. Сорилтын зориулалттай тариаланг үзэх:
  - а) сорт сорилтын тариалан,

b) хамгаалагдсан сорт сортын онцлог шинж чанараа хэвээр хадгалж буй эсэхийг хянах сорилтын тариалан.

(2) Удамшлын тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдийн эрлийзжүүлгээр үржүүлдэг сортуудыг нээлттэй үзүүлэхэд сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргасан этгээдийн хүсэлтээр тухайн удамшлын бүрэлдэхүүн хэсгүүдийн талаарх мэдээллийг ил болгохгүй. Энэхүү хүсэлтийг зөвхөн сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлгийг шийдвэрлэх хүртэлх хугацаанд гаргаж болно.

### **30-р зүйл.Сортын оноосон нэрийг өөрчлөх**

(1) Сорт хамгааллын эрх олгоход бүртгэгдсэн сортын оноосон нэрийг дараахь тохиолдолд өөрчилнө. Үүнд:

1. энэ хуулийн 7-р зүйлийн 2 эсхүл 3-р заалтад нийцэх үл зөвшөөрөх шалтгаан тухайн оноосон нэрийг бүртгэх үед үүссэн бөгөөд энэ нөхцөл байдал нь өөрчлөгдөөгүй бол,
2. энэ хуулийн 7-р зүйлийн 2-р заалтын д. 5 эсхүл 6-д нийцэх үл зөвшөөрөх шалтгаан шинээр үүссэн бол,
3. уг оноосон нэр эрх зүйн зөрчил үүсгэж буй нь итгэл үнэмшилтэйгээр илэрсэн бөгөөд улмаар сорт хамгааллын эрх эзэмшигч тухайн сортыг өөр оноосон нэрээр бүртгэхийг зөвшөөрсөн бол,
4. сорт хамгааллын эрх эзэмшигч сортын оноосон нэрийг ашиглахыг хориглосон эрх зүйн хүчинтэй шийдвэр гарсан бол, эсхүл
5. энэ хуулийн 14-р зүйлийн 1-р заалтын дагуу сортын оноосон нэрийг ашиглах үүрэг хүлээсэн бусад этгээдэд эрх зүйн хүчинтэй шийдвэрээр тухайн сортын оноосон нэрийг ашиглахыг хориглосон бөгөөд сорт хамгааллын эрх эзэмшигч, Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн 68-р зүйлийн хоёр дахь өгүүлбэрт дурдагдсан аль нэг нөхцлөөр өөрийн эрхийг эдлэх боломжгүй болсноос бусад тохиолдолд, хэрэв өөрөө эрх зүйн энэ маргаанд оролцсон эсхүл энэ маргааны талаар түүнд мэдэгдсэн бол.

Энэ заалтын 1-р өгүүлбэрийн д. 1-ийн дагуу сортын оноосон нэрийг өөрчлөх тохиолдолд Захиргааны албан хэрэг хөтлөх тухай хуулийн 48-р зүйлийн 3-р заалтын дагуу хөрөнгийн хохирлыг нөхөн барагдуулахыг нэхэмжлэх эрх үүсэхгүй.

(2) Хэрэв Холбооны Сортын Алба энэ зүйлийн 1-р заалтын дагуу өөрчлөх шалтгаан үүссэнийг тогтоосон бол тодорхой заасан хугацаанд сортын өөр оноосон нэр мэдүүлэхийг сорт хамгааллын эрх эзэмшигчээс шаардана. Заасан хугацаанд шаардлагыг биелүүлээгүй бол Холбооны Сортын Албаэрхийнхээ дагуу тус сортод нэр онооно. Сорт хамгааллын эрх эзэмшигч эсхүл гуравдагч этгээд эрх бүхий сонирхлоо итгэл үнэмшилтэйгээр илэрхийлж чадсан тохиолдолд Холбооны Сортын Алба тухайн этгээдийн хүсэлтээр тухайн сортод нэр онооно. Сортын шинэчлэгдсэн нэрийг оноох, олон нийтэд мэдээлэхэд энэ хуулийн 24 ба 25 зүйл, түүнчлэн 28-р зүйлийн 1-р заалтын д. 1 ба 4-р заалтыг нийцүүлэн хэрэглэнэ.

### **31-р зүйл.Сорт хамгааллын эрхийг дуусгавар болгох**

(1) Сорт хамгааллын эрх эзэмшигч уг эрхээс татгалзаж буйгаа Холбооны Сортын Албанд бичгээр мэдэгдвэл сорт хамгааллын эрх хүчингүй болно.

(2) Хэрэв сорт хамгааллын эрх олгох үед тухайн сорт ялгагдахуйц бус эсхүл шинэ бус байсан нь нөхөн тогтоогдвол сорт хамгааллын эрхийг хураан авна. Энэ тохиолдолд Захиргааны албан хэрэг гүйцэтгэх тухай хуулийн 48-р зүйлийн 3-р заалтын дагуу хөрөнгийн хохирлыг нөхөн барагдуулахыг нэхэмжлэх эрх үүсэхгүй. Өөр шалтгаанаар хураан авахыг үл зөвшөөрнө.

(3) Хэрэв сорт гомоген бус эсхүл тогтворгүй бус болох нь тогтоогдвол сорт хамгааллын эрхийг хүчингүй болгоно.

(4) Түүнчлэн сорт хамгааллын эрх эзэмшигчийн дараахь үйлдэл нь сорт хамгааллын эрхийг хүчингүй болгох үндэслэл болно. Үүнд:

1. энэ хуулийн 30-р зүйлийн 2-р заалтын дагуу сортын оноосон нэрийг өөрчлөн мэдүүлэх үүргээ

биелүүлээгүй,

2. энэ хуулийн 32-р зүйлийн д. 1-д заасан журамд үндэслэсэн, тухайн сорт сортын онцлог шинж чанараа хэвээр хадгалж буй эсэхийг хянах сорилт гүйцэтгэх үүргээ сануулга авсан боловч биелүүлээгүй, эсхүл
3. жилд төлөх албан хураамжийг нөхөн төлөх хугацаанд ч багтаан төлөөгүй.

### **32-р зүйл. Үйл ажиллагааны журам батлах эрх**

Холбооны Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам дараахь зохицуулалтад нийцэх эрх зүйн журам батлах эрхтэй. Үүнд:

1. Холбооны Сортын Албаны үйл ажиллагааг тодорхой зааж өгөх, үүнд ялангуяа сортын ялгагдах байдлыг илэрхийлэх гол шинж тэмдэгүүдийг сонгох, сорт сорилтын цар хүрээг тогтоох, хамгаалагдсан сортууд онцлог шинж чанараа хадгалж буй эсэхийг хянах сорилтыг зохицуулах,
2. Холбооны Сортын Албанаас олон нийтэд мэдэгдэл хийхэд ашиглагдах мэдээллийн хэрэгслийг тодорхойлох.

### **33-р зүйл. Хураамж, нөхөн төлбөр**

(1) Холбооны Сортын Алба нь энэ хуулийн дагуу дангаар үзүүлсэнд тооцогдох олон нийтийн үйлчилгээндээ болон гадаадын эсхүл улс дамнасан байгууллагуудын хүсэлтээр гүйцэтгэсэн сорт сорилтдоо хураамж, нөхөн төлбөр, түүнчлэн сорт хамгааллын эрхийн хүчинтэй хугацаанд жил тутам (сорт хамгаалалтын жил) хураамж авна.

(2) Холбооны Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам нь Холбооны Сангийн Яам болон Холбооны Эдийн засаг, Эрчим Хүчний Яамтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр зохих хууль тогтоомжийн дагуу хураамж ногдуулах ажил үйлчилгээ болон хураамжийн хэмжээг тогтоох, хураамжийн нэг бүрчилсэн буюу суурь тарифуудыг тогтоох, түүнчлэн хураамж үүсэх ба төлөх хугацааг зохицуулах эрхтэй. Үүнд Холбооны Сортын Албанаас үр сортын салбарт буюу нийтэд үзүүлсэн, дангаар гүйцэтгэсэнд тооцогдох олон нийтийн үйлчилгээний ач холбогдол, эдийн засгийн үнэ цэнэ ба бусад ашиг тусыг зохистойгоор тооцож үзнэ. Үйлчилгээний зардлын нөхөн төлбөр тооцох, хураамж авахыг Захиргааны хураамжийн тухай Холбооны хуулиас зөрүүтэйгээр зохицуулж болно.

(3) Захиргааны хураамжийн тухай Холбооны хуулийн 22-р зүйлийн 4-р заалтын нийцүүлэн Холбооны Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамнаас гаргасан Хураамжийн Түсгай Журмын дагуу Холбооны төрийн захиргааны төвшинд үйлчилгээний хураамж үүсэх ба төлөх хугацааг Захиргааны хураамжийн тухай Холбооны хуулинд заагдсан журмаас зөрүүтэйгээр зохицуулж болно.

(4) Сорт сорилтын хураамж авахад, түүнчлэн сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэгт татгалзсан шийдвэр гаргасан тохиолдолд хураамж авахад Захиргааны зардлын тухай хуулийн 2013 оны 8-р сарын 14-нийг хүртэл хүчинтэй үйлчилсэн найруулга дахь 15-р зүйлийн 2-р заалтын дагуу хөнгөлөлт үзүүлэхгүй.

(5) Холбооны Сортын Албанд гаргасан гомдол амжилттай шийдвэрлэгдсэн тохиолдолд гомдол гаргасны хураамж ногдуулна. Гомдлын дагуу Патентын шүүхэд нэхэмжлэл гаргасан эсхүл шүүхэд давж заалдсан тохиолдолд хэрэв амжилттай шийдвэрлэгдсэн бол хүсэлтийн дагуу гомдол гаргасны хураамж ногдуулна. Гомдол хэсэгчлэн шийдвэрлэгдсэн бол гомдол гаргасны хураамжийг хэсэгчлэн ногдуулна. Хэрэв шүүхийн шийдвэр өмнө нь хүчинтэй буюу нотлогдох боломжтой байсан бодит баримтад үндэслэгдсэн бол хураамж ногдуулахгүй эсхүл хэсэгчлэн ногдуулахгүй байж болно. Гомдол шийдвэрлэх зардлын нөхөн төлбөр ногдуулахад энэ заалтын 1-с 4-р өгүүлбэрийг баримтална. Гомдол гаргасан этгээд Захиргааны албан хэрэг гүйцэтгэх тухай хуулийн 80-р зүйлийн дагуу зардлыг буцаан нэхэмжлэх эрхгүй.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **Шүүхээр маргаан шийдвэрлүүлэх**

#### **34-р зүйл. Патентийн шүүхэд нэхэмжлэл гаргах**

- (1) Маргаан шийдвэрлэх хороодын гаргасан шийдвэрийн эсрэг Патентийн шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.
- (2) Заасан нэхэмжлэл гаргах хугацаанд нэхэмжлэлийн хураамжийг Патентийн зардлын тухай хуулийн дагуу төлнө; хураамж төлөгдөөгүй бол нэхэмжлэл гаргаагүй гэж үзнэ.
- (3) Энэ хуулийн 30-р зүйлийн 2-р заалтын дагуу сортын нэр оноосны эсрэг, түүнчлэн гарсан даруйдаа хэрэгжихээр заагдсан шийдвэрийн эсрэг гаргасан нэхэмжлэл тухайн шийдвэрийг хойшлуулах үндэслэл болохгүй.
- (4) Холбооны Сортын Албаны Ерөнхийлөгч нэхэмжлэл хэлэлцэхэд оролцож болно.
- (5) Нэхэмжлэлийг Нэхэмжлэл Хянан Хэлэлцэх Сенат шийдвэрлэнэ. Уг сенат нь энэ хуулийн 18-р зүйлийн 2-р заалтын д. 3 ба 4-т дурдагдсан тохиолдлуудад гурван хуульч гишүүний бүрэлдэхүүнтэйгээр, бусад тохиолдолд нэг хуульч гишүүнээр ахлуулсан өөр нэг хуульч гишүүн ба мэргэжлийн хоёр гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шийдвэр гаргана.

#### **35-р зүйл. Давж заалдах**

- (1) Хэрэв Нэхэмжлэл Хянан Хэлэлцэх Сенат зөвшөөрсөн бол, Нэхэмжлэл Хянан Хэлэлцэх Сенатын шийдвэрийн эсрэг Холбооны улсын шүүхэд давж заалдана.
- (2) Энэ хуулийн 34-р зүйлийн 3-р заалтыг нийцүүлэн хэрэглэнэ.

#### **36-р зүйл. Патентийн тухай хуулийг хэрэглэх**

Энэ хуулийн 34 ба 35-р зүйлд өөрөөр заагаагүй бол Патентийн шүүхэд нэхэмжлэл гаргах болон Холбооны улсын шүүхэд давж заалдахад, түүнчлэн шүүхээр маргаан шийдвэрлүүлэх албан хэргийн зардалд туслалцаа үзүүлэхэд Патентийн тухай хуулийн холбогдох журмууд үйлчилнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **Зөрчил**

#### **37-р зүйл. Хорио тавих, хохирлын нөхөн төлбөр авах ба хураамж авах эрх**

- (1) Сорт хамгааллын эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр
  1. хамгаалагдсан сортын материалаар энэ хуулийн 10-р зүйлийн 1-р заалтад дурдагдсан аль үйлдлийг гүйцэтгэсэн, эсхүл
  2. хамгаалагдсан сортын оноосон нэрийг эсхүл түүнтэй андуурагдахуйц нэрийг тухайн эсхүл ойролцоо төрөл зүйлийн өөр сортод хэрэглэсэн бол,хохирогч талаас зөрчлийг арилгуулах, түүнчлэн уг зөрчил давтагдах аюул байгаа гэж үзвэл хорио тавихыг нэхэмжлэх эрхтэй. Энэ эрх зөрчил гарсан анхны удаад ч хүчинтэй.
- (2) Санаатайгаар буюу болгоомжгүй гаргасан зөрчлийн улмаас хохирол учруулсан этгээд хохирогч талд нөхөн төлбөр төлөх үүрэгтэй. Зөрчил үүсгэсэн этгээд зөрчил үүсгэснээрээ олсон ашгийн хэмжээг нөхөн төлбөр тооцоход харгалзаж болно. Нөхөн төлбөрийг түүнчлэн зөрчил үүсгэсэн этгээд уг сортыг ашиглах зөвшөөрөл авсан тохиолдолд төлөх ёстой байсан хураамжийн хэмжээнд үндэслэн тооцож болно.
- (3) Сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлгийг олон нийтэд мэдээлснээс сорт хамгааллын эрх олгогдох хүртэлх хугацаанд тухайн хамгаалагдсан сортын материалаар энэ хуулийн 10-р зүйлийн 1-р заалтад дурдагдсан аль нэг үйлдлийг гүйцэтгэсэн этгээдээс сорт хамгааллын эрх эзэмшигч

зохистой хэмжээний хураамж шаардах эрхтэй.

(4) (хасагдсан)

### **37а-р зүйл. Устгах, албадан хураах**

(1) Энэ хуулийн 37-р зүйлийн 1-р заалтад дурдагдсан зөрчил үүссэн бол зөрчил үүсгэсэн үйлдэлд ашиглагдсан, зөрчил үүсгэсэн этгээдийн эзэмшиж эсхүл өмчилж буй материалыг устгахыг хохирогч нэхэмжлэх эрхтэй. Тухайн материалыг үйлдвэрлэхэд үндсэндээ ашиглагдсан, зөрчил үүсгэсэн учруулсан этгээдийн эзэмшил дэх багаж хэрэгсэлд 1-р өгүүлбэрийг нийцүүлэн хэрэглэнэ.

(2) Энэ хуулийн 37-р зүйлийн 1-р заалтад дурдагдсан зөрчил үүссэн бол хохирогч зөрчил үүсгэсэн этгээдээс хууль бусаар үйлдвэрлэсэн, тараасан эсхүл хууль бусаар тараахаар бэлтгэсэн материалыг албадан хураах эсхүл түгээлтийн бүх сувгуудаас эргүүлэн татахыг нэхэмжлэх эрхтэй.

(3) Энэ зүйлийн 1 ба 2-р заалтын дагуу авах арга хэмжээ өгөгдсөн нөхцөлд зохисгүй байх тохиолдолд уг арга хэмжээг нэхэмжлэх эрх хүчингүй. Өгөгдсөн нөхцөлд тухайн арга хэмжээ зохистой эсэхийг тодорхойлоход түүнчлэн гуравдагч этгээдийн бодит үндэслэлтэй ашиг сонирхлыг харгалзана.

### **37б-р зүйл. Мэдээлэл авах эрх**

(1) Энэ хуулийн 37-р зүйлийн 1-р заалтад дурдагдсан зөрчил үүсэн бол хохирогч зөрчил үүсгэсэн этгээдээс зөрчил үүсгэсэн материалын гарал үүсэл болон түгээлтийн сувгуудын талаарх мэдээллийг даруй өгөхийг нэхэмжлэх эрхтэй.

(2) Зөрчил үүсэн нь илэрхий тохиолдолд эсхүл хохирогч зөрчил үүсгэсэн этгээдийн эсрэг шүүхэд зарга мэдүүлсэн тохиолдолд хохирогч түүнчлэн арилжааны цар хүрээнд дараахь үйлдлийг хийсэн этгээдээс, уг этгээд нь Иргэний байцаан шийтгэх хуулийн 383-с 385-р зүйлийн дагуу зөрчил үүсгэсэн этгээдийн эсрэг гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэйгээс бусад тохиолдолд, 1-р заалтын дагуу мэдээлэл өгөхийг нэхэмжлэх эрхтэй. Үүнд:

1. эрх зүйн зөрчил үүсгэсэн материалыг өөрийн эзэмшилд байлгасан,
2. эрх зүйн зөрчил үүсгэсэн үйлчилгээг хүртсэн,
3. эрх зүйн зөрчил үүсгэсэн үйлдэлд үйлчилгээ үзүүлсэн, эсхүл
4. энэ заалтын 1, 2 эсхүл дугаар 3-т дурдагдсан үйлдлийг гүйцэтгэсэн өөр этгээдийн мэдүүлснээр эрх зүйн зөрчил үүсгэсэн материалын үйлдвэрлэл буюу борлуулалтад оролцсон.

Энэ заалтын 1-р өгүүлбэрийн дагуу хохирогчийн гаргасан нэхэмжлэлийг шүүхээр шийдвэрлэх тохиолдолд зөрчил үүсгэсэн этгээдийн эсрэг эрх зүйн маргааныг мэдээлэл авах зорилгоор гаргасан эрх зүйн маргаан шийдвэрлэгдэх хүртэл хойшлуулахаар шүүхээс шийдвэрлэж болно. Мэдээлэл өгөхөөр татагдсан этгээд мэдээлэл өгөхөд шаардлагатай зардлыг нөхөн төлөхийг хохирогчоос нэхэмжлэх эрхтэй.

(3) Мэдээлэл өгөхөөр татагдсан этгээд дараахь мэдээллийг өгөх үүрэгтэй:

1. эрх зүйн зөрчил үүсгэсэн материалын үйлдвэрлэгчид, нийлүүлэгчид, өмнө нь эзэмшиж байсан этгээдүүд, үйлчилгээ үзүүлсэн этгээдүүд, түүнчлэн худалдан авагчид болон борлуулалтын цэгүүдийн нэр ба хаяг,
2. үйлдвэрлэсэн, нийлүүлсэн, хүлээн авсан эсхүл захиалсан материалын хэмжээ, түүнчлэн тухайн материалд буюу эсхүл холбогдох үйлчилгээнд төлсөн үнэ хөлс.

(4) Энэ зүйлийн 1 ба 2-р заалтын дагуу авах арга хэмжээ өгөгдсөн нөхцөлд зохисгүй байх тохиолдолд уг арга хэмжээг нэхэмжлэх эрх хүчингүй.

(5) Мэдээлэл өгөхөөр татагдсан этгээд зориудаар эсхүл хайхрамжгүйгээр бүрүү эсхүл дутуу мэдээлэл өгвөл үүнээс учирсан хохирлыг хохирогч талд нөхөн төлөх үүрэгтэй.

(6) Энэ зүйлийн 1-р эсхүл 2-р заалтын дагуу мэдээлэл өгөх үүрэг хүлээгээгүй боловч үнэн зөв мэдээлэл өгсөн этгээд зөвхөн мэдээлэл өгөх үүрэггүйгээ мэдэж байсан тохиолдолд л гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээнэ.



(7) Зөрчил үүссэн нь илэрхий тохиолдолд мэдээлэл өгөх үүргийг Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн 935-с 945-р зүйлд үндэслэсэн шүүхийн түр захирамжаар албажуулж болно.

(8) Мэдээлэл өгөхөөр татагдсан этгээдээс авсан мэдээллийг зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгээр, тухайн этгээдийн эсхүл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 52-р зүйлийн 1-р заалтаар тодорхойлсон төрөл садангийнх нь эсрэг шүүх ажиллагаанд, эсхүл эдгээр этгээдийн мэдээлэл өгөхөөсөө өмнө үйлдсэн үйлдлийг Нийгмийн хэв журмын зөрчлийн тухай хуулийн дагуу шүүх ажиллагаанд ашиглаж болно.

(9) Хэрэв мэдээлэл өгөхөөр татагдсан этгээдээс мэдээлэл авахад харилцаа холбооны бүртгэлийн мэдээлэл ашиглах (Харилцаа холбооны тухай хуулийн 3-р зүйлийн д. 30) зайлшгүй шаардлагатай бол хохирогчийн хүсэлтээр харилцаа холбооны бүртгэлийн мэдээлэл ашиглахыг зөвшөөрсөн шүүхийн захирамж гаргуулсан байх шаардлагатай. Уг захирамжийг гаргах үүрэг мэдээлэл өгөхөөр татагдсан этгээдийн оршин суух хаяг эсхүл албан хаяг буюу салбарын хаяг нь бүртгэгдсэн дүүргийг хариуцсан муж улсын шүүхэд, маргааны мөнгөн дүнгээс хамааралгүйгээр ногдоно. Шийдвэрийг Иргэний танхим гаргана. Шийдвэр гаргахад Гэр бүлийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх болон эрх зүйн маргаангүй асуудлыг шийдвэрлэх тухай хуулийг нийцүүлэн хэрэглэнэ. Шүүхийн захирамж гаргуулахад гарах зардлыг хохирогчоос гаргуулна. Муж улсын шүүхийн захирамжийн эсрэг нэхэмжлэл гаргахыг зөвшөөрнө. Нэхэмжлэлийг хоёр долоо хоногийн хугацаанд багтаан гаргана. Хувь хүнтэй холбоотой мэдээллийн нууцыг хамгаалах журмууд өөр ямарваа хэлбэрээр хөндөгдөхгүй.

(10) Энэ зүйлийн 9-р заалттай холбоотойгоор 2-р заалтаар харилцаа холбооны нууцыг хадгалах суурь эрх (Үндсэн хуулийн 10-р зүйл) хязгаарлагдана.

### **37с-р зүйл. Баримт бичиг, эд зүйлийн үзлэгийн эрх**

(1) Энэ хуулийн 37-р зүйлийн 1-р заалтад дурдагдсан зөрчил үүссэн байх магадлал хангалттай тохиолдолд хуулиар эрх олгогдсон этгээд эсхүл өөр эрх бүхий этгээд нь нэхэмжлэлээ үндэслэхэд хэрэгцээтэй гэж үзсэн, зөрчил үүсгэсэн байж болзошгүй этгээдийн эзэмшилд буй баримт бичиг эсхүл эд зүйлийг үзэхийг зөрчил үүсгэсэн байж болзошгүй этгээдээс нэхэмжлэх эрхтэй. Хэрэв арилжааны цар хүрээнд зөрчил үүссэн бол уг эрх нь түүнчлэн банкны, санхүүгийн буюу худалдааны баримт бичгүүдэд үйлчилнэ. Зөрчил үүсгэсэн байж болзошгүй этгээдийн зүгээс тухайн мэдээлэл нууц гэдгийг нотолж чадвал өгөгдсөн нөхцөлд мэдээллийн нууцыг хамгаалах арга хэмжээг шүүхээс авна.

(2) Энэ зүйлийн 1-р заалтын дагуу нэхэмжлэл гаргах эрх өгөгдсөн нөхцөлд зохисгүй байх тохиолдолд уг эрх хүчингүй.

(3) Баримт бичиг, эд зүйлсээ үзүүлэх буюу үзэхийг зөвшөөрөх үүргийг Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн 935-с 945-р зүйлүүдэд үндэслэсэн шүүхийн түр захирамжаар хүлээлгэнэ. Мэдээллийн нууцыг хамгаалахад шаардлагатай арга хэмжээг шүүхээс авна. Энэ нь ялангуяа эсрэг талын мэдүүлгийг сонсолгүй шүүхийн түр захирамж гаргасан тохиолдлуудад хамаарна.

(4) Иргэний хуулийн 811-р зүйл болон энэ хуулийн 37b-р зүйлийн 8-р заалтыг нийцүүлэн хэрэглэнэ.

(5) Хэрэв зөрчил үүсгэсэн байж болзошгүй этгээд зөрчил үүсгээгүй эсхүл үүсгэхээр завдаагүй бол энэ зүйлийн 1-р заалтын дагуу баримт бичиг, эд зүйл үзэхийг шаардсан этгээдээс, түүний үйлдлээс учирсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

### **37d-р зүйл. Хохирол нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулах**

(1) Арилжааны цар хүрээнд зөрчил үүссэн тохиолдолд хэрэв хохирогч энэ хуулийн 37-р зүйлийн 2-р заалтыг үндэслэн хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ эдлэхэд нь зөрчил үүсгэсэн байж болзошгүй этгээдийн эзэмшилд байгаа банкны, санхүүгийн эсхүл худалдааны баримт бичгүүд шаардлагатай бөгөөд эдгээр баримт байхгүйгээр хохирлыг нөхөн төлүүлэх нь эргэлзээтэй бол, эдгээр баримтуудыг үзүүлэхийг эсхүл үзэх боломж олгохыг зөрчил үүсгэсэн байж болзошгүй этгээдээс нэхэмжлэх эрхтэй. Зөрчил үүсгэсэн байж болзошгүй этгээдийн зүгээс тухайн мэдээлэл нууц

гэдгийг нотолж чадвал өгөгдсөн нөхцөлд мэдээллийн нууцыг хамгаалах арга хэмжээг шүүхээс авна.

(2) Энэ зүйлийн 1-р заалтын 1-р өгүүлбэрийн дагуу нэхэмжлэл гаргах эрх өгөгдсөн нөхцөлд зохисгүй байх тохиолдолд уг эрх хүчингүй.

(3) Хэрэв хохирол нөхөн төлүүлэх эрх үүссэн нь илэрхий бол энэ зүйлийн 1-р заалтад дурдагдсан баримт бичгийг үзүүлэх үүргийг Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн 935-с 945-р зүйлүүдэд үндэслэсэн шүүхийн түр захирамжаар хүлээлгэнэ. Мэдээллийн нууцыг хамгаалахад шаардлагатай арга хэмжээг шүүхээс авна. Энэ нь ялангуяа эсрэг талын мэдүүлгийг сонсолгүй шүүхийн түр захирамж гаргасан тохиолдлуудад хамаарна.

(4) Иргэний хуулийн 811-р зүйл болон энэ хуулийн 37b-р зүйлийн 8-р заалтыг нийцүүлэн хэрэглэнэ.

### **37e-р зүйл. Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх**

Энэ хуульд үндэслэн шүүхэд зарга мэдүүлсэн тохиолдолд, хэрэв зохих үндэслэлтэй бол, шүүхийн шийдвэр нь уг шийдвэрийг ялагдсан талын зардлаар олон нийтэд мэдээлэх эрхийг ялсан талд олгож болно. Олон нийтэд мэдээлэх хэлбэр, цар хүрээг шүүхийн шийдвэрт тодорхой зааж өгнө. Шүүхийн шийдвэр хүчинтэй болсноос хойш гурван сарын дотор энэ эрхийг ашиглаагүй бол эрх хүчингүй болно. Энэ зүйлийн 1-р өгүүлбэрийн дагуу олгогдох эрхийг урьдчилан эдлэх боломжгүй.

### **37f-р зүйл. Нэхэмжлэл хөөн хэлэлцэх хугацаа дуусах**

Энэ хуулиар хамгаалагдсан аливаа эрх зөрчигдсөн гэж үзэн гаргасан нэхэмжлэлийн хөөн хэлэлцэх хугацааг тогтооход Иргэний хуулийн 1-р дэвтрийн 5-р бүлэг дэх журмуудыг нийцүүлэн хэрэглэнэ. Хариуцагч нь зөрчил үүсгэх замаар нэхэмжлэгчийг хохироон ямар нэг ашиг хонжоо хүртсэн бол Иргэний хуулийн 852-р зүйлийг нийцүүлэн хэрэглэнэ.

### **37g-р зүйл. Өөр хуулийн заалтыг үндэслэн нэхэмжлэл гаргах**

Өөр хуулийн заалтад үндэслэн нэхэмжлэл гаргах эрх хөндөгдөхгүй.

### **38-р зүйл. Сорт хамгааллын эрх зүйн маргаан**

(1) Энэ хуулиар зохицуулагдах эрх зүйн харилцаанаас олгогдох эрхээ эдлэхээр мэдүүлсэн бүх заргыг (сорт хамгааллын эрх зүйн маргаан) зөвхөн муж улсын шүүхүүд маргааны мөнгөн дүнг үл харгалзан хариуцна.

(2) Муж улсын Засгийн газрууд хэд хэдэн муж улсын шүүхийн хариуцсан дүүргүүдэд хамааралтай сорт хамгааллын эрх зүйн маргааныг, баримт бүрдүүлэхэд эсхүл маргааныг хурдан шийдвэрлэхэд тустай гэж үзвэл, аль нэг муж улсын шүүхээр шийдвэрлүүлэхээр даалгах эрхтэй. Муж улсын Засгийн газруудэнэ эрхээ муж улсын шүүхийн захиргаадад шилжүүлж болно. Түүнчлэн муж улсууд харилцан тохиолцсоны үндсэн дээр аль нэг муж улсын шүүхэд ногдох үүргийг өөр муж улсын хариуцсан шүүхэд бүтнээр нь буюу хэсэгчлэн шилжүүлж болно.

(3) Хэрэг шийдвэрлэхэд патентийн өмгөөлөгч оролцсоноос үүсэх зардлаас, Өмгөөлөгчийн цалин, хураамжийн тухай хуулийн 13-р зүйлийг үндэслэн тогтоосон өмгөөллийн хураамж болон шаардагдах хэмжээний нөхөн төлбөрийг патентийн өмгөөлөгчид төлүүлнэ.

(4) Энэ зүйлийн 1-с 3-р заалтууд нь түүнчлэн Европын Холбооны Зөвлөлийн 1994 оны 7-р сарын 27-ны өдрийн (EG) 2100/94 тоот “Европын Хамтын Нийгэмлэгийн Сорт Хамгааллын Журам”-ын (ABI. EG д. L 227 х. 1) тухай бүрийн хүчинтэй найруулгаар зохицуулагдах эрх зүйн харилцаанаас олгогдох эрхээ эдлэхээр шүүхэд мэдүүлсэн бүх заргуудад үйлчилнэ.

### **39-р зүйл. Шийтгэл ногдуулах журам**

(1) Доорх үйлдэлд гурван жил хүртэл хорих ялаар шийтгэнэ эсхүл мөнгөн шийтгэл ногдуулна:

1. Энэ хуулийн 10-р зүйлийн 1-р заалтыг зөрчин, мөн 2-р заалттай холбоотойгоор, энэ хуулиар

хамгаалагдсан сортын үржүүлгийн материал, ургамал, ургамлын эд эрхтэн эсхүл бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үржүүлгийн зорилгоор бэлтгэх, ашиглах, импортлох, экспортлох эсхүл хадгалах, эсхүл

2. Европын Холбооны Зөвлөлийн 1994 оны 7-р сарын 27-ны өдрийн (EG) 2100/94 тоот “Европын Хамтын Нийгэмлэгийн Сорт Хамгааллын Журам”-ын (АВЛ. EG д. L 227 х. 1) 13-р зүйлийн 1-р заалтыг, 2-р заалтын 1-р өгүүлбэртэй, мөн 4-р заалтын 1-р өгүүлбэртэй эсхүл 5-р заалттай холбоотойгоор зөрчин, Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгааллын журмаар хамгаалагдсан сортын материалыг үржүүлэх, үржүүлэх зорилгоор бэлтгэх, борлуулахаар санал болгох, ашиглах, импортлох, экспортлох эсхүл хадгалах.

(2) Гэм буруутай үйлдлийг арилжааны зорилгоор үйлдсэн этгээдэд таван жил хүртэл хорих ял эсхүл мөнгөн шийтгэл ногдуулна.

(3) Оролдлогод мөн шийтгэл ногдуулна.

(4) Хууль сахиулах байгууллага олон нийтийн онцгой ашиг сонирхлын үүднээс мөрдөн шалгах үйл ажиллагааг эрхийнхээ хүрээнд гүйцэтгэх шаардлагатай гэж үзсэнээс бусад тохиолдолд энэ зүйлийн 1-р заалтад дурдагдсан хэргийг зөвхөн нэхэмжлэлийн дагуу шалгана.

(5) Гэмт үйлдэлд холбогдох эд зүйлийг албадан хурааж болно. Эрүүгийн хуулийн 74а-р зүйлийг хэрэглэнэ. Энэ хуулийн 37а-р зүйлд дурдагдсан нэхэмжлэлтэй хэргийг хохирогчид нөхөн төлбөр олгуулах тухай Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалтуудын (403-с 406-с-р зүйл) дагуу шийдвэрлэсэн бол эд зүйл хурааж авах тухай заалтуудыг хэрэглэхгүй.

(6) Шийтгэл ногдуулах шүүхийн тогтоол гарсан тохиолдолд хэрэв хохирогч хүсэлт гаргасан бөгөөд уг хүсэлт нь бодит үндэслэлтэй бол нэхэмжлэлийн дагуу шийтгэл ногдуулсан шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэхийг шүүхээс захирамжилна. Олон нийтэд мэдээлэх хэлбэрийг шүүхийн тогтоолд тодорхой заасан байна.

#### **40-р зүйл. Хэв журмын зөрчилд торгууль ногдуулах журам**

(1) Санаатай эсхүл болгоомжгүйгээр үйлдсэн дараахь үйлдлийг хэв журам зөрчсөнд тооцно. Үүнд:

1. Энэ хуулийн 14-р зүйлийн 1-р заалтыг зөрчин, энэ хуулиар хамгаалагдсан сортын үржүүлгийн материалыг, сортын оноосон нэрийг хэрэглэлгүйгээр эсхүл зааварласны дагуу хэрэглэлгүйгээр ашиглах,
2. Энэ хуулийн 14-р зүйлийн 3-р заалтыг зөрчин, энэ хуулиар хамгаалагдсан сортын оноосон нэрийг эсхүл түүнтэй андуурагдахуйц нэрийг ижил эсхүл ойролцоо төрөл зүйлийн ургамлын сортонд хэрэглэх, эсхүл
3. Европын Холбооны Зөвлөлийн 1994 оны 7-р сарын 27-ны өдрийн (EG) 2100/94 тоот “Европын Хамтын Нийгэмлэгийн Сорт Хамгааллын Журам”-ын (АВЛ. EG д. L 227 х. 1) 17-р зүйлийн 1-р заалтыг зөрчин, мөн 3-р зүйлтэй холбоотойгоор, Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгааллын журмаар хамгаалагдсан сортын оноосон нэрийг үл хэрэглэх, зүй бусаар хэрэглэх, бүрэн бусаар хэрэглэх, эсхүл зааварласнаас өөрөөр хэрэглэх.

(2) Хэв журам зөрчсөн үйлдэлд таван мянга хүртэл евроны торгууль ногдуулна.

(3) Хэв журам зөрчсөн үйлдэлд холбогдох эд зүйлийг хурааж авч болно. Хэв журмын зөрчлийн тухай хуулийн 23-р зүйлийг хэрэглэнэ.

(4) Хэв журмын зөрчлийн тухай хуулийн 36-р зүйлийн 1-р заалтын д. 1 дэх “Төрийн захиргааны алба” гэдэгт Холбооны Сортын Албыг тооцно.

#### **40а-р зүйл. Гаалийн байгууллагаас арга хэмжээ авах журам**

(1) Европын Парламент ба Европын Холбооны Зөвлөлийн 2013 оны 6-р сарын 12-ны өдрийн (EU) 608/2013 тоот “Оюуны өмчийн эрхийг хамгаалах талаар гаалийн байгууллагуудаас авах арга хэмжээний тухай болон Европын Холбооны Зөвлөлийн (EG) 1383/2003 тоот журмыг хүчингүйд тооцох тухай журам”-ын (АВЛ. 2013 оны 6-р сарын 29-ний өдрийн L 181, х. 15) тухай бүрийн

хүчинтэй найруулга хэрэглэгдэхгүй тохиолдолд, дотоодын хууль тогтоомжоор олгогдсон сорт хамгааллын эрхийг зөрчсөн, эсхүл Европын Холбооны Зөвлөлийн 1994 оны 7-р сарын 27-ны өдрийн (EG) 2100/94 тоот “Европын Хамтын Нийгэмлэгийн Сорт Хамгааллын Журам”-ын (ABl. EG д. L 227, х. 1) тухай бүрийн хүчинтэй найруулгын дагуу олгогдсон Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгааллын эрхийг зөрчсөн материалыг, зөрчил илэрхий тохиолдолд, сорт хамгааллын эрх эзэмшигчийн гаргасан нэхэмжлэл ба барьцаа хөрөнгийн баталгааг үндэслэн импортлохоор буюу экспортлохоор завдах үед нь гаалийн байгууллагатур хураана. Гэрээт улсуудтай хийгдэх барааны тээвэр, солилцоонд энэ заалт нь зөвхөн гаалийн байгууллагуудаас хяналт тавих тохиолдолд үйлчилнэ.

(2) Гаалийн байгууллага тухайн материалыг түр хураах шийдвэр гаргасан бол энэ тухайгаа уг материалыг эзэмшигч этгээд болон нэхэмжлэгч этгээдэд даруй мэдэгдэнэ. Нэхэмжлэгч этгээдэд материалын гарал үүсэл, хэмжээ, хадгалж буй байршил, түүнчлэн материал эзэмшигчийн нэр, хаягийг мэдэгдэнэ; захиа, шуудангийн нүүцлалын эрх(Үндсэн хуулийн 10-р зүйл) үүгээр хязгаарлагдана. Хэрэв бизнесийн буюу үйлдвэрлэлийн нүүцэд харшлахгүй бол, тус материалыг үзэх боломжийг нэхэмжлэгч этгээдэд олгоно.

(3) Энэ зүйлийн 2-р заалтын 1-р өгүүлбэрийн дагуу түр хураах шийдвэрийг мэдэгдсэнээс хойш хоёр долоо хоногийн дотор албан журмаар эсэргүүцэл гаргаагүй бол гаалийн байгууллага түр хураагдсан материалыг албадан хураана.

(4) Материал эзэмшигч этгээдтүр хураалтын эсрэг албан журмаар эсэргүүцэл гаргавал гаалийн байгууллага энэ тухай нэхэмжлэгч этгээдэд даруй мэдэгдэнэ. Энэ тохиолдолд нэхэмжлэгч этгээд саатуулагдсан материалтай холбоотойгоор энэ зүйлийн 1-р заалтын дагуу гаргасан нэхэмжлэл нь хүчинтэй хэвээр эсэх талаар гаалийн байгууллагад даруй мэдэгдэх үүрэгтэй.

1. Нэхэмжлэгч этгээд нэхэмжлэлээ эргүүлэн татвал гаалийн байгууллага түр хураалтыг даруй цуцална.
2. Нэхэмжлэгч этгээд нэхэмжлэлээ хүчинтэй хэвээр буйг мэдэгдэж, түр хураасан материалыг нэмж саатуулах эсхүл уг материалыг эзэмших эрхийг хязгаарлах тухай шүүхийн шийдвэрийг ирүүлбэл гаалийн байгууллагаас шаардлагатай арга хэмжээг авна.

Энэ заалтын д. 1-тэсхүл2-т дурдагдсан нөхцөл үүсээгүй бол гаалийн байгууллагаас энэ заалтын 1-р өгүүлбэрийн дагуу нэхэмжлэгч этгээдэд мэдэгдсэнээс хойш хоёр долоо хоногийн дараа түр хураалтыг цуцална; нэхэмжлэгч этгээдд. 2-ын дагуу шүүхийн шийдвэр гаргуулахаар хүсэлт гаргасан боловч шүүхийн шийдвэр түүнд хараахан ирээгүй байгаа тухай нотолгоо ирүүлбэл түр хураалтыг хоёр долоо хоног хүртэл хугацаагаар сунгаж болно.

(5) Түр хураалт анхнаасаа үндэслэлгүй нь тогтоогдсон бөгөөд нэхэмжлэгч этгээдэнэ зүйлийн 1-р заалтын дагуу гаргаса н нэхэмжлэлээ хүчинтэй хэвээр байлгасан эсхүл даруй тайлбар өгөөгүй (4-р заалтын 2-р өгүүлбэр) бол материал эзэмших эрх бүхий этгээдэд түр хураалтаас учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

(6) Энэ зүйлийн 1-р заалтын дагуу нэхэмжлэлийг Гаалийн Ерөнхий Газарт гаргах ба нэхэмжлэлд богино хугацаа тусгайлан заагаагүй бол хөөн хэлэлцэх хугацаа нь нэг жил байна; нэхэмжлэлийг давтан гаргаж болно. Нэхэмжлэлтэй холбоотой албан хэргийн зардлыг Татварын ерөнхий хуулийн 178-р зүйлийг баримтлан нэхэмжлэгч этгээдээр төлүүлнэ.

(7) Хэв журмын зөрчлийн тухай хуулийн мөнгөн торгууль ногдуулах арга хэмжээний тухай заалтуудаар зөвшөөрөгдсөн эсэргүүцэл гаргах боломжийг үндэслэн түр хураалт болон албадан хураалтын эсрэг эсэргүүцэл гаргаж болно. Эсэргүүцлийг хэлэлцэхэд нэхэмжлэгч этгээдийн мэдүүлгийг сонсоно. Дүүргийн шүүхийн шийдвэрийн эсрэг муж улсын дээд шүүхэд давж заалдаж болно.

#### **40b-р зүйл. Европын Холбооны (EU) 683/2003 тоот журмын дагуу арга хэмжээ**

Энэ хуулийн 40a-р зүйлийн 5 ба 6-р заалтыг Европын Холбооны 1383/2003 тоот журмын дагуу авах арга хэмжээнд, хэрэв харшлах заалтууд уг журамд байхгүй бол, нийцүүлэн хэрэглэнэ.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ

### Нэмэлт заалт

#### 41-р зүйл. Шилжүүлэн зохицуулах журмууд

(1) Энэ хууль үйлчилж эхлэх үед

1. Үрийн тухай хуулийн Холбооны улсын Төрийн мэдээллийн III боть, дугаар 7822-1-д хэвлэгдсэн, сүүлд 1966 оны 12-р сарын 23-нд нэмэлт өөрчлөлт орсон найруулгын (BGBl. I x. 686) дагуу, 1968 оны 5-р сарын 20-нд батлагдсан Сорт хамгаалах тухай хуулийн (Холбооны улсын Төрийн мэдээлэл I x. 429) 1977 оны 1 сарын 4-нд хэвлэгдсэн хувилбарын (BGBl. I x. 105, 286) 52-р зүйлийн 1-р заалттай холбоотойгоор, сорт хамгааллын эрх нь хүчинтэй хэвээр байгаа сортуудын хувьд, эсхүл
2. 1968 оны 5-р сарын 20-нд батлагдсан Сорт хамгаалах тухай хуулийн тухай бүрийн хүчинтэй найруулгаар сорт хамгааллын эрх нь олгогдсон буюу сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг нь бүртэгдсэн сортуудын хувьд

энэ хуульд заагдсан журмууд дараахь нөхцөлтэйгээр үйлчилнэ: д.1-т дурдагдсан сортуудын хувьд зөвхөн Үрийн тухай хуулийн 2-р зүйлийн 2-р заалтын урьдчилсан нөхцлүүд сорт хамгааллын эрх олгох үед биелээгүй байсан нь тогтоогдсон тохиолдолд л энэ хуулийн 31-р зүйлийн 2-р заалтын дагуу сорт хамгааллын эрхийг хураан авах боломжтой.

(2) Энэ хууль тухайн ургамлын төрөл зүйлд хамааран үйлчилж эхлэхээс өмнө ямар нэг сортыг буюу уг сортын селекцийн ямар нэг аргачлалыг патентжуулсан эсхүл патент эзэмшихээр мэдүүлэг гаргасан бол, мэдүүлэг гаргагч буюу буюу түүний дараахь эрх бүхий этгээд мэдүүлгээ үргэлжлүүлэн гаргах, эсхүл патент эзэмшигч патентаа үргэлжүүлэн эзэмших, эсхүл эдгээр этгээд тухайн сортын хамгааллын эрхийг эзэмших мэдүүлэг гаргах эрхтэй. Хэрэв сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргавал патент эзэмших мэдүүлгийнхээ хугацааны эрэмбийг сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэгтээ тооцуулах хугацааны давуу эрх эдэлнэ; энэ хуулийн 23-р зүйлийн 2-р заалтын 3-р өгүүлбэрийг нийцүүлэн хэрэглэнэ. Олгогдсон сорт хамгааллын эрхийн хүчинтэй хугацааг патент эзэмших мэдүүлэг гаргасан огноо ба сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргасан огнооны хоорондох хуанлийн бүтэн жилүүдээр хорогдуулж тооцно. Сорт хамгааллын эрх олголт маргашгүй болсноос хойш тухайн сортод патент эзэмшигчийн буюу патент эзэмших мэдүүлэг гаргагчийн эрх үйлчлэхгүй; тухайн үед явагдаж буй патент олгох ажиллагаа зогсоно.

(3) Хэрэв ямар нэг сортод Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгааллын эрх олгогдсон ба уг эрхийг цуцлах буюу хүчингүйд тооцох нөхцлүүд биелээгүй нөхцөлд татгалзлын улмаас дуусгавар болсон бол татгалзал хүчинтэй болсноос хойш гурван сарын дотор багтаан энэ хуулийн дагуу сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргаж болно. Уг мэдүүлгийг Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгааллын эрх эзэмшигч буюу түүний дараахь эрх бүхий этгээд гаргахад Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргасан хугацааны эрэмбийг энэ хуулийн дагуу сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэгтээ тооцуулах хугацааны давуу эрх эдэлнэ. Хүсэлт гаргагч заасан хугацаанд багтаан Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргасантай болон уг эрх олгогдсонтой холбоотой баримт бичгүүд, түүнчлэн уг эрх дуусгавар болсон тухай холбогдох баримт бичгүүдийг ирүүлээгүй бол хугацааны давуу эрх хүчингүй болно. Тухайн сортод энэ хуулийн дагуу сорт хамгааллын эрх олгогдох тохиолдолд сорт хамгааллын эрхийн хүчинтэй хугацааг Европын Хамтын Нийгэмлэгийн сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргасан огноо ба энэ хуулийн дагуу сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргасан огнооны хоорондох хуанлийн бүтэн жилүүдээр хорогдуулж тооцно.

(4) Энэ хууль тухайн ургамлын төрөл зүйлд хамааран үйлчилж эхэлснээс хойш нэг жилийн дотор гаргасан сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэгт хамаарах сортыг, хэрэв тухайн сортын үржүүлгийн материалыг эсхүл ургацыг эрх бүхий этгээдийн эсхүл түүний өмнөх эрх бүхий этгээдийн зөвшөөрөлтэйгээр дурдагдсан огнооноос өмнөх дөрвөн жилээс хэтрэхгүй хугацаанд, усан үзэм болон модны төрөл зүйлүүдэд дурдагдсан огнооноос өмнөх зургаан жилээс хэтрэхгүй хугацаанд арилжааны зорилгоор ашигласан бол, шинэ гэж үзнэ. Энэ заалтын 1-р өгүүлбэрийн

дагуу сорт хамгааллын эрх олгогдсон тохиолдолд уг эрхийн хүчинтэй хугацааг тухайн сортыг ашиглаж эхэлсэн огноо ба сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргасан огнооны хоорондох хуанлийн бүтэн жилүүдээр хорогдуулж тооцно.

(5) Хэрэв сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэг гаргасан огноо 1997 оны 7-р сарын 17-ны хуулийн (BGBl. I x. 1854) 1-р зүйл үйлчилж эхэлснээс хойших нэг жилд багтах бол, тухайн сортын ургамал буюу ургамлын эд эрхтнийг мэдүүлэг гаргасан огноог хүртэл арилжааны зорилгоор ашиглаагүй, эсхүл эрх бүхий этгээдийн буюу түүний өмнөх эрх бүхий этгээдийн зөвшөөрөлтэйгээр мэдүүлэг гаргасан огнооноос өмнөх дор дурдсан хугацаанд багтанарилжааны зорилгоор ашигласан тохиолдолд, энэ хуулийн 6-р зүйлийн 1-р заалтаас зөрүүтэйгээр, уг сортыг шинэ гэж үзнэ:

1. дотоодод 1 жил,
2. гадаадад 4 жил, усан үзэм (*Vitis L.*) болон модны төрөл зүйлүүдэд 6 жил.

(6) Энэ хуулийн 10-р зүйлийн 1-р заалтыг 1997 оны 7-р сарын 17-ны хуулийн (BGBl. I x. 1854) 1-р зүйл үйлчилж эхлэхээс өмнө гаргасан сорт хамгааллын эрх эзэмших мэдүүлэгт эсхүл олгогдсон сорт хамгааллын эрхэд хамаарах хоёрдогч сортуудад хэрэглэхгүй.

(7) Иргэний хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 229-р бүлгийн 6-р зүйлийг нийцүүлэн хэрэглэхдээ хуулийн 2002 оны 1-р сарын 1-нийг хүртэл хүчинтэй найруулгын 37с-р зүйлийг Иргэний хуулийн 2002 оны 1-р сарын 1-нийг хүртэл хүчинтэй найруулга дахь нэхэмжлэл хөөн хэлэлцэх хугацаа дуусах тухай журмуудтай адилтган үзнэ.

#### 42-р зүйл.

(Хууль хүчин төгөлдөр болох)

#### Хавсралт

Бичвэрийн эх сурвалж: Холбооны улсын Төрийн мэдээлэл, I 1997, 3176

Үржүүлгийн материалыг нь тариалалтад эргүүлэн ашиглах боломжтой таримал ургамлын төрөл зүйлүүд:

- |   |                       |
|---|-----------------------|
| 1. Үр тариа   |                       |
| 1.1 <i>Avena sativa L.</i>                            | Хошуу будаа           |
| 1.2 <i>Hordeum vulgare L. sensu lato</i>              | Арвай                 |
| 1.3 <i>Secale cereale L.</i>                          | Хөх тариа             |
| 1.4 <i>x Triticosecale Wittm.</i>                     | Тритикале             |
| 1.5 <i>Triticum aestivum L. emend. Fiori et Paol.</i> | Зөөлөн буудай         |
| 1.6 <i>Triticum durum Desf.</i>                       | Хатуу буудай          |
| 1.7 <i>Triticum spelta L.</i>                         | Спельт улаан буудай   |
| 2. Тэжээлийн ургамал                                  |                       |
| 2.1 <i>Lupinus luteus L.</i>                          | Шошлой (люпин)        |
| 2.2 <i>Medicago sativa L.</i>                         | Царгас                |
| 2.3 <i>Pisum sativum L. (partim)</i>                  | Вандуй                |
| 2.4 <i>Trifolium alexandrinum L.</i>                  | Александрын хошоонгор |
| 2.5 <i>Trifolium resupinatum L.</i>                   | Перс хошоонгор        |
| 2.6 <i>Vicia fabia L. (partim)</i>                    | Шош                   |
| 2.7 <i>Vicia sativa L.</i>                            | Таримал гиш           |
| 3. Тосны ба эслэгийн ургамал                          |                       |
| 3.1 <i>Brassica napus L. (partim)</i>                 | Рапс                  |

3.2 *Brassica rapa* L. var. *silvestris* (Lam.) Briggs

Сармаг

3.3 *Linum usitatissimum* L.

Маалинга

4. Төмс

4.1 *Solanum tuberosum* L.

Төмс